



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоо
санхүүжүүлэв



АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх, үүрэг, оролцоо

Модуль 2. Бидний эрх



Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоо
санхүүжүүлэв

АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх үүрэг, оролцоо

Модуль 2. Бидний эрх

Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2020
Анхны хэвлэл 2020

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцын 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу. Олон улсын хөдөлмөрийн товчоо ийм хүсэлтийг таатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

Амьдрах ухааны сургалтын багц: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо, Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчоо — Бээжин: ОУХБ, 2020

ISBN:978-92-2-0325605 (хэвлэмэл) ISBN:978-92-2-0325612 (веб pdf)

Мөн Англи хэлээр: 3-R Trainers' Kit: Rights, Responsibilities and Representation for Children, Youth and Families. ISBN:978-92-2-0325599 (web pdf), Ulaanbaatar, 2020

МЭДЭГДЭЛ: 2020 ОНЫ ШИНЭЧИЛСЭН ХЭВЛЭЛ (МОНГОЛ, АНГЛИ ХУВИЛБАР)

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат(MNG/17/50/EUR)”-ны хүрээнд зөвлөх Бусакорн Суриясарн, Х.Өлзийтунгалаг нар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран боловсруулав.

Энэхүү сургалтын багцын үндсэн мэдээллийг дараах эх үүсвэрээс авч, Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулав: Empowerment for Children, Youth and Families: 3-R Trainers' Kit on Rights, Responsibilities and Representation, ISBN: 92-2-117849-8 (print), 92-2-117850-1 (web pdf), 92-2-117851-X (CD-ROM), Bangkok (2006) болон the 2017 edition, ISBN 978-92-2-130249-0 (print); 978-92-2-130250-6 (web pdf).

Уг сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

НҮБ-ын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын хэвлэл нийтлэлд ашиглагдсан тодорхойлолт, тусгагдсан материалууд нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бүс, газар нутаг, эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаар тогтоохтой холбоотой ямарваа үзэл бодол илэрхийлээгүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа, бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчооноос хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш юм.

Байгууллагуудын болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүний нэр, үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой байгууллагын нэр, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь ч тэдгээрийг үгүйсгэсэн асуудал биш болно.

ОУХБ-ын хэвлэл, цахим бүтээгдэхүүний талаарх мэдээллийг www.ilo.org/publns хаягаар авах боломжтой.

Уг сургалтын багцын агуулга, түүнд илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид өөрсдөө хариуцах бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Хавтасны болон дотор зургийг Ай Си Си Ди ХХК зурав.

Хэвлэлийн эх, график дизайныг Соёмбо принтинг ХХК-д бэлтгэж, Монгол Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Сүүлийн 10 жилд Монгол Улсын Засгийн газраас Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын 1999 оны 182 дугаар конвенц болон Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенцыг хэрэгжүүлэх чиглэлд олон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Энэхүү хүчин чармайлт нь “Тогтвортой хөгжлийг хангах хөтөлбөр 2030”-ын хүрээнд дэвшүүлсэн 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах зорилтуудтай бүрэн нийцэж байгаа юм.

Тогтвортой хөгжлийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл дэх хүүхдийн болон албадан хөдөлмөрийн талаарх ойлголтыг дээшлүүлэх шаардлага зайлшгүй байгааг холбогдох талууд онцолж байна. Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, залуучууд, гэр бүлтэй ажиллах чиг үүрэг бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд ийм хэрэгцээ шаардлага бүр чухлаар тавигдаж байгаа юм.

“Амьдрах ухааны сургалт: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо” сэдэвт сургагч багшид зориулсан сургалтын энэхүү багц нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой. ОУХБ-аас анх 2006 онд боловсруулан гаргасан уг сургалтын багц гарын авлага олон оронд амжилттай хэрэглэгдэж байгаагийн дотор Монгол Улсад ОУХБ-АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд 2007 оноос хэрэглэж эхэлсэн юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) энэхүү сургалтын багц гарын авлагыг төрийн болон төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд хамгийн тохиромжтой, ач холбогдолтой хэмээн үзэж, Монголын нөхцөлд нийцүүлэн боловсруулахаар шийдвэрлэсэн билээ.

ОУХБ-аас Европын Холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төслийн¹ хүрээнд уг багц гарын авлагыг ийнхүү шинэчлэн боловсруулж, агуулгыг үндэсний сургагч багш нараар хэлэлцүүлэн баталгаажууллаа. Энэхүү сургалтын багцыг олон хүн ашиглаж, хамгийн хэрэгцээтэй зорилтот бүлэгтээ хүрч үр өгөөжөө өгнө гэж найдаж байна. Энэ цаг үед нүүрлээд буй КОВИД-19 цар тахал эмзэг бүлгийн, ялангуяа хүүхдийн аж байдалд хар сүүдрээ тусгаж, шинэ эрсдэл үүсгэж байна. Үүнээс үүдээд ирэх жилүүдэд эдийн засагт гарч болзошгүй таагүй өөрчлөлтийн нөхцөлд дэлхий даяар засгийн газар, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэлүүд болон иргэний нийгмийн байгууллагууд 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг, 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг устгах зорилтуудыг хэрэгжүүлэх тун амаргүй сорилттой тулгарч байна. Энэхүү үйлсэд уг сургалтын багц бага ч болов хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Энэхүү багц гарын авлагыг шинэчлэн боловсруулж гаргах боломжийг бүрдүүлж, санхүүгийн харамгүй туслалцаа үзүүлсэн Европын Холбоонд ОУХБ, ГБХЗХГ гүн талархлаа илэрхийлье. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэнийг ч орхигдуулахгүй хамтдаа хөгжих зарчмыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болж, хүн амын эмзэг бүлгийг дэмжих чиглэлд бидний хамтын ажиллагаа үргэлжилнэ гэж найдаж байна.

Мижидсүрэнгийн Энх-Амар
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын дарга

Клэйр Куртье-Мюлдэр
ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг
хариуцсан товчооны захирал

¹ Төслийн бүтэн нэр: “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат” (MNG/17/50/EUR)

АГУУЛГА

Өмнөх үг	iii
Талархал	vii
Модулийн агуулга	1
Сэдэв 2.1 Хүн бүр эрхтэй	2
Дасгал 2.1.1 Хүний эрх гэж юу вэ?	3
СХ 2.1.1 А: “Би ямар эрхтэй вэ?” дасгал	8
СХ 2.1.2 Б: “Би ямар эрхтэй вэ?” хариултын хуудас	9
Нэмэлт мэдээлэл: Хүний эрх	10
Дасгал 2.1.2 Би юу хийх ёстой вэ?	14
СХ 2.1.2 А: Багийн ажилд зориулсан асуултууд: Эрх болон үүрэг хариуцлага	17
Нэмэлт мэдээлэл: Эрх болон үүрэг хариуцлага	19
Сэдэв 2.2 Хүүхдийн эрх	20
Дасгал. 2.2.1 Надад эрх бий – сандалтай бүжиг	21
СХ 2.2.1 А: Хүүхдийн эрхийг илэрхийлсэн зурагт карт	24
Нэмэлт мэдээлэл: Монгол улс дахь хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал	25
Дасгал. 2.2.2 Би өөрөө шийдвэрлэж чадна	28
СХ 2.2.2 А: Зурагт карт	30
Дасгал. 2.2.3 Би өөрийнхөө эрхийг мэднэ	33
Дасгал. 2.2.4 Хүүхдүүд ч мөн эрхтэй - Зурагт хуудас бүтээх аян	36
Сэдэв 2.3 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх	40
Дасгал. 2.3.1 Олуулаа хэлэлцвэл буруугүй – эвлүүлдэг тоглоом	41
СХ 2.3.1 А: Дүрс эвлүүлэх тоглоом	44
СХ 2.3.1 Б: Ажиглагчийн тэмдэглэл хөтлөх хуудас	45
Нэмэлт мэдээлэл: Эвлэлдэн нэгдэх эрх ба дүрс эвлүүлэх аргачлал	46
Дасгал. 2.3.2 Эвлэлдэн нэгдэцгээе	48
СХ 2.3.2 А: Хөлийн мөрийн зураг	51
Унших материал	52

ТАЛАРХАЛ

Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулсан энэхүү багц гарын авлага нь ГБХЗХГ, ОУХБ-ын хамтын ажиллагаа, тууштай хүчин чармайлтын үр дүн юм.

Энэхүү ажилд олон улсын зөвлөх Бусакорн Суриясарн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч үнэтэй хувь нэмэр оруулсныг талархан тэмдэглэж байна.

Мөн ГБХЗХГ-аас байгуулсан сургалтын багцыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн дараах гишүүдэд талархлаа илэрхийлье. Үүнд:

- Пүрэвсүрэнгийн Алгирмаа (Модуль 4, 9, 10)
- Гомбын Ариунчимэг (Модуль 11)
- Жанцандоржийн Азжаргал (Модуль 2, 4, 9)
- Батсүхийн Батсайхан (Модуль 1, 3)
- Цанлигийн Баттуяа (Модуль 4)
- Сосорбурамын Болорцэцэг (Модуль 10, 11)
- Шархүүгийн Галбадрах (Модуль 6, 7)
- ЛГБТ Төв (Модуль 6)
- Баянбаатарын Оюундарь (Модуль 5, 8)
- Борбандийн Санжид (Модуль 3)
- Хуажингийн Өлзийтунгалаг (Сургагч багшийн гарын авлага).

Түүнчлэн энэхүү ажлыг санаачлан эхлүүлж, дэмжсэн ГБХЗХГ-ын дарга асан Очирбатын Алтансүх, дэд дарга Болдбаатарын Халиун нарт талархаж байна. Сургалтын багцыг үндэсний нөхцөлд тохируулан боловсруулахад шаардагдах мэдээллээр хангаж, монгол орчуулгыг хянан дэлгэрэнгүй санал, зөвлөмж өгч хувь нэмрээ оруулахын зэрэгцээ уг ажлыг уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэсэн ГБХЗХГ-ын Гэр бүл, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Жанцандоржийн Азжаргал, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш Хуажингийн Өлзийтунгалаг нарт талархлаа илэрхийлье. Мөн орчуулагчаар ажилласан Ванжилын Бэрцэцэг, Баттулгын Нармандах, монгол хэлээрх хувилбарыг хянан тохиолдуулсан Балчиндоржийн Туяа нарт талархаж байна.

ОУХБ-ын зүгээс уг ажилд Амгалангийн Лхагвадэмбэрэл, Баярсайханы Баярцэцэг, Бээжин дэх товчооны Париссара Льюкийт, Бангкок дахь Зохистой хөдөлмөрийг дэмжих багийн Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Барати Флюг нар хөтөлбөрийн, захиргааны болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан болно.

МОДУЛЬ 2. БИДНИЙ ЭРХ

Модулийн агуулга

Энэхүү модуль нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн суурь эрх болон эдгээр эрхтэй холбоотой үүрэг, хариуцлагын талаар танилцуулна. Энэ модуль нь хүний эрхийг хийсвэр талаас нь бус, харин оролцогчдын өдөр тутмын амьдралтай холбож ойлгуулахад чиглэсэн юм. Оролцогчид хүний суурь эрхтэй холбоотойгоор хүлээх үүрэг хариуцлагын талаар эргэцүүлэх болно. Түүнчлэн хүний суурь эрхийг хамгаалах, суурь эрхийн зөрчилтэй тэмцэхэд хүчээ нэгтгэхийн ач холбогдлыг тусгасан болно.

Энэ модуль үндсэн 3 сэдвээс бүрдэнэ. Үүнд:

- Сэдэв 2.1 Хүн бүр эрхтэй
- Сэдэв 2.2 Хүүхдийн эрх
- Сэдэв 2.3 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх

2.1 Хүн бүр эрхтэй	Зорилго	Хугацаа
Дасгал. 2.1.1 Хүний эрх гэж юу вэ?	• Хүний эрхийн утга санааг ойлгох	75 минут
Дасгал. 2.1.2 Би юу хийх ёстой вэ?	• Эрхийг үүрэг хариуцлага дагалддаг болохыг ойлгох • Улс орныхоо сайн иргэн, нутаг усныхаа сайн гишүүн байх үүрэг, хариуцлагаа ойлгох	90 минут
2.2 Хүүхдийн эрх	Зорилт	Хугацаа
Дасгал. 2.2.1 Надад эрх бий-Сандалтай бүжиг	• Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох	60 минут
Дасгал. 2.2.2 Би өөрөө шийдвэрлэж чадна	• Эрхийг үүрэг хариуцлага дагалддаг гэдгийг ойлгох • Янз бүрийн хүмүүсийн эрх хоорондоо зөрчилдөж болохыг ойлгох • Зөрчлийг шийдвэрлэх боломжит хувилбаруудын талаар эргэцүүлэх	60 минут
Дасгал. 2.2.3 Би өөрийнхөө эрхийг мэднэ	• Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох • Хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдолд тусламж хүсэх арга замаа мэдэх	60 минут
Дасгал. 2.2.4 Хүүхдүүд ч мөн эрхтэй – Зурагт хуудас бүтээх аян	• Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох • НҮБ-ын ХЭК-ын ач холбогдлыг ойлгох	60 минут
2.3 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх	Зорилтууд	Хугацаа
Дасгал. 2.3.1 Олуулаа хэлэлцвэл буруугүй – эвлүүлдэг тоглоом	• Хамтран ажиллахад өөрийн хүч чадлаа дайчлахын ач холбогдлыг ойлгох • Хамтран ажиллахын давуу талыг мэдрэх	60 минут
Дасгал. 2.3.2 Эвлэлдэн нэгдэцгээе	• Хамтын ажиллагаанд хувь хүний хүчин чармайлтын чухлыг ойлгох • Зорилгодоо хамтдаа хүрэх	60 минут
Хугацаа 8 цаг 45 минут		

Сэдэв 2.1 Хүн бүр эрхтэй



Агуулга

Энэхүү сэдэв нь та бүхэнд хүний үндсэн суурь эрхүүдийн талаар мэдлэг, ойлголт өгөх юм. Оролцогчид хүний эрхийг дээдлэн хүндлэхийн ач холбогдол шаардлагыг ойлгож, эрх тэгш бус байдлыг таньж сурна. Оролцогчид эрх эдлэхийн хамтаар иргэн хүний хүлээх үүрэг хариуцлага байдгийг мэдэх болно. Мөн янз бүрийн хүмүүсийн эрх хоорондоо зөрчилдөж болохыг ойлгож, ийм зөрчлийг шийдвэрлэх арга замын талаар эргэцүүлнэ.



Үндсэн мэдээлэл

- Төрсөн газар, хүйс, язгуур угсаа, шашин шүтлэг, баян ядуу гэр бүлээс гаралтай эсвэл баян ядуу улс оронд амьдардгаас үл хамааран хүн гэдэг утгаараа бүгд ижил тэгш эрхтэй.
- Хүний үндсэн эрхийг улс орон бүрийн үндсэн хууль болон холбогдох хуулиар баталгаажуулсан байдаг.
- Хүний үндсэн эрхийг хэр зэрэг дээдэлж байгаа нь тухайн улс орон, орон нутаг, гэр бүлд ялгаатай байдаг.
- Засгийн газар нь иргэн бүрт эрхээ эдлэх боломж олгох үүрэгтэй.
- Эрхийг дагаад хүлээх үүрэг хариуцлага гарч ирдэг. Хүн бүр эрхээ эдлэх эрхтэй ч бусад хүмүүсийн эрхийг зөрчиж болохгүй.
- Бид өөрсдийн эрх төдийгүй бусад хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлага хүлээдэг.



Дасгалууд

2.1.1 Хүний эрх гэж юу вэ?

2.1.2 Би юу хийх ёстой вэ?



Холбогдох сэдвүүд

2.2 Хүүхдийн эрх

2.3 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх

4.2 Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?

11.2 Хөдөлмөрлөх эрх

Дасгал 2.1.1 Хүний эрх гэж юу вэ?



Зорилго

Хүний эрхийн утга санааг ойлгох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

75 минут



Суудал зохион байгуулалт

Голдоо том зай гаргаж сандлуудыг том тойргоор байрлуулна.



Ашиглах материал

- Самбар
- Самбарын цаас 10 ш. (1-10 хүртэл дугаарлана)
- Цүнх эсвэл ваар
- 6 болон түүнээс олон самбарын үзэг



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.1.1 А: “Би ямар эрхтэй вэ?” дасгал

2.1.1 Б: “Би ямар эрхтэй вэ?” хариултын хуудас

Нэмэлт мэдээлэл: Хүний эрх



Сургалт зохион байгуулах алхмууд²

1. Санаа цуглуулах арга: Хүн байхын утга учрыг юу гэж ойлгох вэ? – 15 минут
2. Хүний эрх гэж юу вэ? – 15 минут
3. Хүний үндсэн эрхүүд – 35 минут
4. Дүгнэлт – 10 минут

² Human Rights Here and Now: Celebrating the Universal Declaration of Human Rights by Nancy Flowers, ed. (Human Rights Resource Center, University of Minnesota), Activity 1: Human Beings/Human Rights, <http://hrlibrary.umn.edu/edumat/hreduseries/hereandnow/Part-3/Activity1.htm>.

Бэлтгэл

Алхам 3-т зориулж цүнх эсвэл ваар, мөн 10 ширхэг самбарын цаас (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.1 А)

Алхам 1. Санаа цуглуулах арга: Хүн байхын утга учрыг юу гэж ойлгох вэ? – 15 минут

“ХҮН” гэдэг үгийг самбар эсвэл самбарын цаасны голд бичнэ. “Хүн” гэдэг үгийн доор хүн зурж, оролцогчдоос дараах асуултыг асуугаарай. Үүнд:

- Хүнийг ямар онцлог шинжүүд тодорхойлдог гэж бодож байна вэ?
- Хүн байх нь амьтнаас юугаараа ялгаатай вэ?

Оролцогчид магадгүй хүн хоёр хөл дээрээ босоо явдаг, ярьж чаддаг, бичиж чаддаг, барилга, байшин барьж чаддаг, техник, урлаг, уран барилга, шинэ технологи зэрэг бүтээлч зүйлийг туурвидаг зэргээр хариулах байх. Оролцогчид хариулж дууссаны дараа “Хүн”-ий зургийн зүүн талд тэдний хэлсэн санааг үгээр эсвэл бэлэг тэмдгээр төлөөлүүлэн бичээрэй (эсвэл оролцогчдыг өөрийн санааг бичих эсвэл зурахыг санал болгоорой). Зарим оролцогч оюун ухаан, сэтгэл хөдлөл, сайхан сэтгэл зэрэг шинжүүдийг нэрлэж магадгүй. Энэ үед тэдэнд санаа оноогоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгоорой.

Оролцогчдоос дараах асуултыг асуугаарай:

- Хүнийг юу аз жаргалтай, баяр баясгалантай болгодог вэ? Таныг юу аз жаргалтай, баяртай болгодог вэ? Өөрийн хамгийн дотно хүмүүс тухайлбал аав, ээж, эмээ, өвөө, хүүхдүүд, ах, эгч, дүү, хамаатан садан, найз нөхдийнхөө тухай бодоорой. Тэднийг юу аз жаргалтай болгодог вэ?
- Хамгаалагдсан байх, аз жаргалтай сайхан амьдрах, хөгжиж дэвжих, нөөц боломжоо хэрэгжүүлэхэд хүнд юу хэрэгтэй вэ?

Ихэнх оролцогч тэдний суурь хэрэгцээ болох орон байр, мөнгө, эрүүл мэнд, халамжтай гэр бүл, боловсрол, ажил хөдөлмөр зэргийг дурдах байх. Зарим нь хайр, тав тух, сайн найз нөхөд, өөрийн амьдардаг орон нутаг гэх мэт санаа хэлэх байх. Тэдний бүх хариултыг “Хүн”-ий зургийн баруун талд жагсаан бичээрэй.

Үүний дараа дараах асуултын дагуу санаа цуглуулаарай:


- “Хүн” байна гэдэг нь зөвхөн “Амьд байх” эсвэл “Эсэн мэнд орших” гэсэн үг үү? (Үгүй, өөрийн нөөц боломжийг бүрэн нээхийн тулд өөрийгөө хөгжүүлнэ гэсэн үг)
- Хүн бүр нэр төр, эрхэм чанартай байхыг хүсдэг үү? (Тийм. Хүн бүр хүндлэл хүлээх, хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг)
- Хүн бүр өөрийн гэр бүл, орон нутаг, өөрийн улс орондоо шударга байдлыг хүртэх, бусдын адил үнэ цэнэтэй байх эрхтэй юу? (Тийм. Хүн бүр шударга байдлыг хүртэх эрхтэй. Гэвч энэ бүхэн бодит амьдралд тэр болгон хэрэгждэггүй)
- Хүмүүс юу бодож, юу мэдэрч, юу хүсэж байгаагаа бусдад үг яриагаар дамжуулан илэрхийлдэг. Заримдаа хэн нэг нь үзэл бодлоо илэрхийлэх энэхүү эрх чөлөөг нь хязгаарладаг. Хэрвээ танд ийм зүйл тохиолдвол та дуртай байх уу? (Үгүй)
- Эсэн мэнд амьдрах үндсэн хэрэгцээнээс гадна та өөр юу хүсэж байна вэ? (Эрүүл мэнд, аюулгүй байдал, ядуурал/хүчирхийллээс хамгаалагдах, баян байх, эрх мэдэлтэй байх гэх мэт).

Хүний зургийн баруун талд нэмэлт хариултуудыг жагсаан бичээрэй. Эдгээр хариулт нь “нэр төр”, “аюулгүй байдал”, “тэгш эрх”, “хүндэтгэл”, “эрх чөлөө”, “хөгжих боломжууд” зэрэг байна.

Алхам 2. Хүний эрх гэж юу вэ? – 15 минут

Оролцогчдын хариултын жагсаалт дээр, хүний дүрсийн хажууд “ЭРХ” гэж бичээд дараах асуултыг оролцогчдоос асуугаарай:

Эрх гэж юу вэ?



Зарим хариулт, санаа бодлыг хуваалцаад “Хүний эрх гэж юу вэ?” гэсэн богино дүрс бичлэг үзүүлнэ. Энэхүү дүрс бичлэгийг НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос эрхлэн гаргасан юм (ОНЧНР). Бичлэгийн үргэлжлэх хугацаа 1.44 мин: <https://www.youtube.com/watch?v=JpY9s1Agbsw>. Дүрс бичлэг нь бүх насны хүмүүст тохиромжтой бөгөөд бичиг үсгийн боловсролгүй хүмүүст ч мөн ойлгомжтой хэлбэрээр хийгдсэн болно.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Интернэтэд хүний эрхийн үзэл баримтлалыг тайлбарласан богино хэмжээний олон дүрс бичлэг бий. Түүний зарим нь хүүхдүүдэд, зарим нь залуучууд болон насанд хүрэгчдэд зориулагдсан юм. Сургагч багш нар зорилтот бүлэгт тохирсон богино хэмжээний дүрс бичлэг сонгож үзүүлнэ. Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссоос гаргасан зарим дүрс бичлэгийг санал болгов.

<https://www.youtube.com/watch?v=SK4NcMBLjyQ> (59 секунд)

<https://www.youtube.com/watch?v=wP1v5ab2toU> (9.36 минут).


Дүрс бичлэг үзүүлсний дараа дараах санааг тайлбарлаарай. Үүнд:

- “Эрх” гээд ярихад хэн нэг нь хуулийн хүрээнд эрхтэй, харин нөгөө тал тухайн эдлэх ёстой эрхийг хамгаалах үүрэг, хариуцлагатай гэсэн үг. Өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй хүмүүс, хүүхдүүд бүгд “хүний эрх”-ийг эдлэх ёстой бөгөөд засгийн газар тэдний эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.
- Хүний эдгээр эрхийг (наад захын стандартын хувьд) улс орнууд, засгийн газрууд бичиж, хэлэлцэж, хүлээн зөвшөөрсөн байдаг. Улмаар энэ нь олон улсын хууль болон батлагдаж, улс орон бүр дагаж мөрдөх үүрэг хариуцлага хүлээдэг.
- Хүний эрх түгээмэл шинжтэй. Хүн бүр - охид, хөвгүүд, эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар оронд амьдардаг, ямар хэлээр ярьдаг, баян, ядуу, шашин шүтлэгээс үл хамааран - хүн гэдэг утгаараа бүгд ижил тэгш эрхтэй.
- Бүх улс орны Засгийн газар хүн бүрийн эрхийг хангахын тулд дараах үүрэг хариуцлага хүлээнэ. Үүнд:
 - ХҮНДЭТГЭХ (хүний хийж чадах зүйлд хязгаар тавихаас зайлсхийх)
 - ХАМГААЛАХ (аливаа хүчирхийллээс хамгаалах)
 - ХЭРЭГЖҮҮЛЭХ (өөрийн нөөц боломжийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах).
- Улс орон бүр хүний эрхийн суурь стандартыг хангуулах хууль, тогтоомжтой байдаг. Энэ нь Үндсэн хууль юм. Жишээлбэл: Монгол Улс иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах Үндсэн Хуультай. Хүний эрхийг зөрчсөн тохиолдолд зөрчил, гэмт хэрэг гэж үзэж хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Зарим улс орны хуулиуд болон олон улсын гэрээ конвенцод хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалахад онцгой анхаарсан байдаг. Учир нь тэд аливаа хүчирхийлэл дарамтад өртөх эрсдэлтэй байдаг (Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэмэлт мэдээллийн 1-р хэсгээс хараарай).

Алхам 3. Хүний үндсэн эрхүүд – 35 минут

Тоглоом тоглонгоо хүний үндсэн 10 эрхийг мэдэж авна гэдгийг оролцогчдод хэлнэ. Тоглоом нь 2 үе шаттай.

Нэгдүгээрт, доорх зурагт харуулснаар 10 ширхэг хоосон самбарын цаасыг 3x4 метрийн хэмжээтэй том тэгш өнцөгтийн зайд байрлуулна. Цаасаа 1-10 хүртэл дугаарлана. Оролцогчид цаас тус бүрийг тойрч болохоор цаасны хооронд хангалттай зай байгаа эсэхээ шалгаарай.



Оролцогчдыг 5 багт хуваана. Баг бүрээс нэг гишүүн гарч ирээд цүнх болон шилэн савнаас гүйцэтгэх даалгаврыг сугална. Цаасан дээрээс дугаар болон гүйцэтгэх даалгавраа олно. Даалгавраа хийхийн тулд шалан дээрээс тохирох дугаартай самбарын цаасыг ашиглана. Энэхүү даалгаврыг 5 минутын хугацаанд гүйцэтгэнэ гэдгийг сануулаарай.

Багууд даалгавраа гүйцэтгэсний дараа үлдсэн 5 цаасан дээр ажиллаарай.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хэрвээ сургалтад хүүхдүүд оролцож байвал тэдэнд хүний зарим эрхийг ойлгоход жаахан хүндрэлтэй байж магадгүй. Тэд бүх эрх дээр ажиллах шаардлагагүй. Тийм учраас тэдэнд амархан ойлгох даалгавар өгч болно. Жишээлбэл: Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.1 А.-гаас 2, 3, 4, 5, 6, 8, 10-р эрхийг сонгож болно.

Бүх цаасан дээр ажиллаж дууссаны дараа оролцогчдыг баг бүрийн хийсэн ажилтай танилцахыг санал болгоно. Баг бүрээс дараах асуултын дагуу ажлаа танилцуулахыг хүсэж, бүх дэлгэц цаасан дээр дараалан ажиллана:

- Энд хүний аль эрхийг тусгасан байна вэ?
- Энэ эрхтэй холбоотой ямар даалгавар гүйцэтгэсэн бэ?
- Энэ эрхтэй холбоотой даалгаврыг гүйцэтгэхэд хэр зэрэг хүндрэлтэй байсан бэ? (Жишээ болон санаа)

Бусад багийн гишүүд нөгөө багийн гаргасан санал, хариулт, жишээ, зураг зэргийг зөвшөөрч байгаа эсэхийг асуугаарай. Хэрвээ тэд нэмэлт санал хэлэх хүсэлтэй байвал нэмж болно. Шаардлагатай бол эрх бүр дээр дутуу мэдээллийг нэмж болно (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.1 Б-гээс хариултыг харна уу).



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Англи хэл мэддэг хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд хүний эрхийн төвөөс гаргасан 4.30 минутын хугацаатай хүний эрхийн үндсэн санааг тусгасан дүрс бичлэг үзүүлж болно 2008.³

Багийн ажлыг хэлэлцэж эсвэл бичлэг үзсэний дараа хүний эрхийн түгээмэл тунхаглал үүссэн түүхийн талаар товчхон ярьж өгч болно (Дэлгэрэнгүй мэдээллийг “Нэмэлт мэдээллийн 2-р хэсгээс үзнэ үү). Багийн ажлаас хүний үндсэн эрхийг товчхон дүгнээд, гэрлэх, өрх тусгаарлах эрх, нийгэм, соёлын үйл ажиллагаанд оролцох эрх, хуулийн хүрээнд тэгш байх эрх зэрэг хүний бусад эрхийн талаар товчхон дүгнэж ярина. Хэрвээ цаг хүрвэл хүний эрхийн түгээмэл тунхаглалын талаар дурдаарай (Нэмэлт мэдээлэл, 3-р хэсэг).

Алхам 5. Дүгнэлт -10 минут

Хүнд зөвхөн амьд явах хэрэгцээ төдийгүй аз жаргалтай, сайн сайхан амьдрахад өөр бусад хэрэгцээ ч чухал.

Бидэнд дараах 3 төрлийн суурь хэрэгцээ байдаг. Үүнд:

1. Хүн бүрт хоол хүнс, хувцас хунар, орон гэр, эрүүл байлгах эм тариа, аюулгүй байдал, аюул эрсдэлээс хамгаалагдсан байх зэрэг суурь хэрэгцээ байдаг.
2. Өөрийн нөөц боломжоо бүрэн дүүрэн нээхийн тулд бүх хүн боловсрол эзэмших, ажил хөдөлмөр эрхлэх хэрэгтэй. Түүнчлэн бид орон нутаг, амьдарч байгаа газартаа харьяалагдах, хүндлэл хүлээх, ижил тэгш эрхтэй, эрх чөлөөтэй байх ёстой. Энэ бүгд нь эрхэм чанараа мэдрэх мэдрэмжийг бий болгож байдаг.
3. Хэрвээ бид дээрх боломжуудаар хангагдчихвал бидэнд хэрэгцээтэй байгаа дараагийн зүйлийн талаар бодож эхэлдэг. Энэ нь тухайлбал, гэр бүлээрээ тав тухтай амьдрах том байшин, унаа тэрэг, хүүхдэд зориулсан чанартай тоглоом, загварлаг хувцас, үзвэр үйлчилгээ, гар утас, видео тоглоом зэрэг бидэнд ая тухыг бэлэглэдэг зүйл юм. Эдгээр зүйл нь зайлшгүй шаардлагатай биш ч бидэнд баяр хөөрийг өгдөг.

Энэ бүгдэд хүний үндсэн эрх хамааралтай эсэх талаар оролцогчдоос асуугаарай. Хүний эрх нь хүний ая тух, тансаг хэрэглээг хамрах уу? (Үгүй, хүний эрх нь хүний эсэн мэнд амьдрах, нэр төртэй амьдрах эрхээ эдлэхэд шаардлагатай наад захын нөхцөлийг баталгаажуулдаг).

Оролцогчдоос өөрийн улс орон/орон нутагт хүний аль эрх нь хангагдахгүй байгаа талаар асууна. Асуудлыг товч хэлэлцэж, дараах санааг онцолж дасгалыг дуусгана:

- Хүн бүр нас, хүйс, гарал угсаа, нийгэм, соёлын ялгаа, яс үндэс, шилжин суурьшсан байдал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол зэргээс үл хамааран үндсэн эрхтэй.
- Хүний эдлэх ёстой үндсэн эрхүүд нь Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид баталгаажсан байдаг.
- Хүний эрхийн хэрэгжилт нь тухайн гэр бүл, орон нутаг болон тухайн улс оронд ялгаатай байдаг.
- Засгийн газар нь иргэдийнхээ эрхийг хангах, хамгаалах үүрэг хүлээсэн байдаг ч хүн нэг бүрийн эрх засгийн газрын хамгаалалтад тогтмол байж чаддаггүй. Ийм ч учраас хүн бүр өөрийн эдлэх ёстой эрхээ мэддэг байх ёстой.

³ The video titled The Universal Declaration of Human Rights created by Seth Brau (producer: Amy Poncher) is available on YouTube <https://www.youtube.com/watch?v=hTlrSYbCbHE> (Human Rights Action Center, 2008), and on Vimeo: <https://vimeo.com/1823335>.



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.1 А: "Би ямар эрхтэй вэ?" дасгал

Зааварчилгаа: Дараах хүснэгтийг зураасан шугамын дагуу хайчилж 10 хэсэгт хуваагаарай. Тус бүрийг нь дундуур нь нугалаад цүнх юмуу шилэн саванд хийнэ. Даалгаврыг өөрчилж болох ч бүх 10 эрхийг оруулна.

1. Самбарын цаасан дээр бичих: АМЬД ЯВАХ, ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ, ХАЛДАШГҮЙ ДАРХАН БАЙХ ЭРХ Энэхүү эрх зөрчигдөж байгаа жишээ гаргах	2. Самбарын цаасан дээр бичих: ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛТАЙ БАЙХ ЭРХ Иргэний харьяалалтай байх нь яагаад чухал болохыг тайлбарлах
3. Самбарын цаасан дээр бичих: НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТЭГШ ХАМРАГДАХ ЭРХ Нийгмийн үйлчилгээний жагсаалт гаргах	4. Самбарын цаасан дээр бичих: СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ Энэхүү эрхтэй холбоотой та өөрийн хүсэж байгаа зүйлийн талаар эргэцүүлээрэй. Энэ нь таны өөрийн хүсэл эсвэл бусад хүмүүсийн хүсэл байж болно. Хүслээ самбарын цаасан дээр бичээрэй.
5. Самбарын цаасан дээр бичих: ХӨДӨЛМӨРЛӨХ, ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ, ШУДАРГА НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ ЭРХ Энэхүү эрх болон энэхүү эрх зөрчигдөж байгааг харуулсан зураг (хэд хэдэн зураг байж болно) зурах.	6. Самбарын цаасан дээр бичих: БООЛЧЛОЛООС АНГИД БАЙХ ЭРХ Хүн бүрийн ангид байх ёстой боолчлолын хэлбэрүүдийн жишээ гаргах
7. Самбарын цаасан дээр бичих: ТЭГШ ЭРХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХ Энэхүү эрх зөрчигдсөн тохиолдлуудын талаар жишээ хэлэх	8. Самбарын цаасан дээр бичих: ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХ Энэхүү эрх зөрчигдсөн эсвэл хязгаарлагдсан тохиолдол, нөхцөл байдлын талаар сонсож байсан бол хуваалцах
9. Самбарын цаасан дээр бичих: ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ Үг хэлэх эрх зөрчигдсөн жишээнүүд гаргах. Улс төр, соёл, шашинтай холбоотой асуудал, түүнчлэн зарим сэтгэл мэдрэмжийн талаар эргэцүүлэн тунгаагаарай.	10. Самбарын цаасан дээр бичих: ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ Байгуулж (элсэж) болох бүлгэм, эвсэл, холбооны жагсаалт гаргах



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.1 Б: “Би ямар эрхтэй вэ?” хариултын хуудас

1. АМЬД ЯВАХ, ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ, ХАЛДАШГҮЙ ДАРХАН БАЙХ ЭРХ – Амьд явах эрх нь хүний суурь эрхийн нэг юм. Энэ нь хүн дайн, зэвсэгт мөргөлдөөн, гэмт хэрэг, хуулийн хэрэгжилтийн улмаас хохирч, амь насаа алдах ёсгүй гэсэн үг. Засгийн газар нь зөвхөн дайн, зэвсэгт мөргөлдөөн, гэмт хэргийн улмаас төдийгүй ядуурал, гэр оронгүй байх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах хомс боломж зэрэг нийгэм эдийн засгийн шалтгаан болон ялгаварлан гадуурхалтын улмаас иргэдийн амьд явах эрх алдагдах явдлыг гаргахгүй байх үүрэгтэй.
2. ИРГЭНИЙ ХАРЬААЛАЛТАЙ БАЙХ ЭРХ – Хүн бүр иргэний харьяалалтай байх, харьяаллаа солих эрхтэй бөгөөд хэн ч энэхүү эрхийг нь дур мэдэн цуцлах ёсгүй. Иргэний харьяалалгүй хүн эх оронгүй, хаана ч хамааралгүй болоод зогсохгүй тухайн улс орны иргэдийн эдлэх эрхийг эдэлж чадахгүйд хүрдэг. Түүгээр зогсохгүй хувь хүний хувьд хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхээ эдэлж чадахгүй. Тухайлбал, сургуульд сурах, санал өгөх, ажил хөдөлмөр эрхлэх, өөрийн эд хөрөнгө эзэмших, эрүүл мэндийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдах боломжгүй болно. Ямар ч харьяалалгүй амьдрах нь хууль бусаар хил нэвтэрсэн гэж баривчлагдах, буруутгагдах магадлалыг нэмэгдүүлдэг.
3. НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТЭГШ ХАМРАГДАХ ЭРХ – Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээ нь хамгийн түгээмэл жишээ юм. Бусад жишээ: дэд бүтэц, нийтийн тээврийн хэрэгсэл, зам, цахилгаан, ус. Оролцогчид нийгмийн зарим нэг бүлгүүд эрх тэгш байх эрхээ эдэлж чадахгүй, өөрөөр хэлбэл нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа талаар санаа гаргавал үүний шалтгааныг товчхон ярилцаарай.
4. СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ – Ямар ч хүсэл сонирхол гарч ирж болно. Оролцогчид охид, хөвгүүдийн сурч боловсрох тэгш эрхийн талаар дурдахгүй бол энэ талаар юу бодож байгаа талаар асуугаарай.
5. ХӨДӨЛМӨРЛӨХ, ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ ШУДАРГА НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ ЭРХ – Хийсэн хөдөлмөртэй тэнцэх ажлын хөлс, ажлын цаг, ажилд орох, албан тушаал дэвших, бизнес эрхлэх ижил боломж, хүүхдийн хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, тэгш байдал (үл ялгаварлан гадуурхах) эсвэл хөдөлмөрийн аюулгүй байдлыг харуулсан бүх зураг зөв.
6. БООЛЧЛОЛООС АНГИД БАЙХ ЭРХ – Албадан хөдөлмөрлүүлэх эсвэл өөрийн төлөөс болгох; хүчээр хөдөлмөрлүүлэх, хорих (тухайлбал, ажил олгогчийн гэрийг орхих эрхгүй гэрийн ажилтан); бэлгийн мөлжлөгт ашиглах; хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулах (цэрэг хүүхэд), ачигчаар ажиллуулах зэргээр боолчлол, боолчлолтой ижил нөхцөлийн жишээ олон байдаг. Оролцогчдоос мэдээллийг хаанаас (өөрийн туршлага, сургууль эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээс) олж авсныг нь асууж ярилцаарай.
7. ТЭГШ ЭРХ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХ – Охид, хөвгүүдийн хувьд боловсрол эзэмших, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ажил хөдөлмөр эрхлэх ижил боломжоор хангагдах, бүх хүн хуулийн өмнө тэгш байх зэргээр хариултууд олон янз байж болно. Хамгийн гол нь гарал үүсэл, нас, хүйс, шашин шүтлэг, улс төр, нийгэм эдийн засгийн үзүүлэлтээс үл хамааран хүн гэдэг утгаараа хүн бүр ижил тэгш боломж эдлэх эрхтэй байх асуудал юм.
8. ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХ – Хариулт нь ямар мэдээлэлд (өөрийн туршлага, ам дамжсан яриа, хэвлэл мэдээллийн хэрэгслээс үү?) суурилсныг оролцогчдоос асууна. Хүн бүр чөлөөтэй зорчих, аялах эрхтэй гэдгийг тайлбарлана. Гэвч энэ эрх нь зарим улс орны зарим хүмүүст, зарим цаг хугацаанд зөрчигдөж байдаг. Зарим улс оронд шилжин суурьшигчдын чөлөөтэй зорчих эрх нь хязгаарлагдмал байдаг.
9. ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ – Зарим улс оронд засгийн газар эсвэл ажил олгогчоо шүүмжлэхийг зөвшөөрдөггүй. Мөн олон орны ёс заншилд хүүхэд эцэг эхийнхээ өөдөөс үг сөрөх эрхгүй байдаг бөгөөд хань ижлээ сонгох, ДОХ өвчин туссан тухай, бэлгийн чиг баримжаа өөр байх зэрэг олон асуудлыг эцэг эхтэйгээ чөлөөтэй ярилцдаггүй. Түүнчлэн ямар шашин шүтэхээ сонгох эрх, хүний итгэл үнэмшлийн асуудал үүнд бас хамаарна.
10. ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ – Соёл, нийгэм, улс төрийн хөдөлгөөн/бүлгэм гээд бүгдийг нэрлэж болно. Жишээ нь: Эвсэл, нэгдэл, Төрийн бус байгууллага, залуучуудын бүлгэм, эцэг эхийн холбоо, улс төрийн нам, холбоо, эвсэл, өөртөө туслах бүлгүүд, хуримтлалын бүлгүүд, хоршоо гэх мэт.



Нэмэлт мэдээлэл: Хүний эрх⁴

1. Хүний эрх гэж юу вэ?

Хүний эрх гэдэг нь хүн болж төрсний хувьд хүн бүрд хамааралтай суурь эрх юм. Хүний эрх түгээмэл учраас нас, хүйс, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан хүн бүр ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Хүний эрх нь эрх чөлөө, нэр төрд халдсан үйлдлээс хүнийг хамгаалах эрх зүйн баталгаа болдог.

“Эрх” гэж ярихад хэн нэг нь хуулийн хүрээнд эрхтэй бөгөөд харин нөгөө тал тухайн эдлэх ёстой эрхийг хангуулах, хамгаалах хуулийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагатай гэсэн үг. Засгийн газар нь иргэдийнхээ эрхийг хамгаалж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг хүлээдэг. Хүн бүр эдгээр эрх, эрх чөлөөг ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой ч эрхийн хэрэгжилт нь нэг улс орноос нөгөө улс оронд ялгаатай байх нь бий.

Хүний эрхийн хамгийн чухал шинж чанарууд бий. Үүнд:

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн
- Хуулиар хамгаалагдсан
- Хүний нэр төрд суурилсан
- Хувь хүн болон бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг
- Төр засаг, төр засгийн субъектүүдэд үүрэг, хариуцлага хүлээлгэдэг
- Цуцлагдахгүй
- Ижил тэгш, харилцан хамааралтай
- Түгээмэл шинжтэй

2. Хүний эрх

1930-аад оны сүүл, 1940-өөд оны үед фашист дэглэмийн дарангуйлал; Дэлхийн 2-р дайны үеэр байгуулагдсан хүн ардыг үй олноор устгах хорих лагерьнуудын балмад ажиллагаа; орон гэргүй болсон сая сая хүмүүс; Хирошима, Нагасаки хотод хаясан атомын бөмбөг зэрэг олон аймшигт үйл явдал дэлхийг цочроосон билээ. Ийм аймшигт үйл явдлууд дахин хэзээ ч давтагдахгүй байх, хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр НҮБ байгуулагдсан. 1948 онд НҮБ-ын Ерөнхий ассамблей Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлан гаргасан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хүмүүс үг хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй, айх аюулгүй, гачигдал зовлонгүй байх” хэмээн хэм хэмжээ тогтоосон. Дор хүний үндсэн эрхийг тусгасан болно.

- Амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрх
- Тэгш эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх
- Иргэний харьяалалтай байх, харьяаллаа өөрчлөх эрх
- Эд хөрөнгө өмчлөх эрх
- Аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх
- Сурч боловсрох эрх
- Гэрлэх, гэр бүл болох эрх
- Нийгэм, соёлын амьдралд оролцох эрх

⁴ WWRGE Manual – Cambodia by Rosalinda Terhorst et al. (ILO: Bangkok, 2004), Briefing Note 6: Rights, Laws and Rules; Inspiring Practice: Resources, Tools and Activities for Human Rights Education by Northern Ireland Human Rights Commission (NIHRC, 2008), http://www.nihrc.org/uploads/publications/Inspiring_Practices.pdf.

- Улсдаа төрийн алба хаших тэгш эрх
- Хөдөлмөрлөх, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах эрх
- Албадан хөдөлмөр эрхлэх болон боолчлолоос ангид байх эрх
- Баривчлах, тарчлаан зовоох үйл ажиллагаанаас ангид байх эрх
- Чөлөөтэй зорчих, шилжин суурьших эрх
- Өөрийн үзэл бодол, санаагаа чөлөөтэй илэрхийлэх эрх
- Тайван замаар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх
- Шашин шүтэх эрх
- Хуулийн хүрээнд хамгаалагдах эрх

Хүний эрхийн тухай хуулинд иргэний болон олон нийтийн эрхийн талаар тусгайлан заасан байдаг. Олон улсын, бүсийн, үндэсний хэмжээний, орон нутгийн түвшинд хүний эрхийн хэрэгжилтэд хүний эрхийн комисс, шүүх, парламент, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үйлдвэрчний эвлэлийн холбоо, ТББ, орон нутагт суурилсан байгууллагууд, шашны байгууллагууд болон шинжлэх ухааны байгууллагууд хяналт тавьж ажилладаг.

3. Олон улсын хүний эрхийн тунхаглал Монголд

Хүний эрхийн стандартыг НҮБ-ын гишүүн улс орнууд боловсруулж, гарын үсэг зурж, соёрхон баталж, олон улсын гэрээнд тусгасан байдаг. Тухайн улс орон олон улсын гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж, гэрээнд нэгдэн орсон тохиолдолд тухайн гэрээг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээж, түүнд заасан дүрэм, стандартыг дагаж мөрдөх ёстой. НҮБ-ын гишүүн орны хувьд Монгол улс хүний эрхийн талаарх олон улсын олон гэрээнд гарын үсэг зурж, соёрхон баталсан. Тухайлбал:

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протокол
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II протокол
- Албадан зайлуулах, хөөхөөс бүх хүнийг хамгаалах тухай конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
- Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц
- Хүүхдийн эрхийн конвенц
- Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай Конвенцод оруулах нэмэлт протокол
- Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц⁵

4. Үндэсний хууль тогтоомж

Хүний эрх нь улс орны үндэсний хууль тогтоомжоор тодорхойлогддог бөгөөд ихэвчлэн Үндсэн хуулиар олгогдсон эрх, Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон засгийн газрын хууль тогтоомжид тусгагдсан байдаг.

⁵ UN Office of the High Commissioner for Human Rights (OHCHR), http://tbinternet.ohchr.org/_layouts/TreatyBodyExternal/Treaty.aspx?CountryID=119&Lang=EN.

4.1 Монгол Улсын Үндсэн хууль

Улс орон бүр иргэний үндсэн эрхийг баталгаажуулсан үндсэн хууль, тогтоомжтой. Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу тус улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх бөгөөд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн заасан (14-р зүйл). Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж тусгажээ. Үүнд:

- Амьд явах эрх
- Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх
- Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх
- Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрх. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.
- Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрх
- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх
- Сурч боловсрох эрх
- Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх
- Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрх
- Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх
- Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх
- Халдашгүй, чөлөөтэй байх эрх
- Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрх
- Шашин шүтэх, эс шүтэх эрх
- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх
- Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх
- Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрх⁶

4.2 Иргэний хууль

Иргэний эрх гэдэг нь хүнийг төр, нийгмийн зүгээс дур зоргоор оролцохоос хамгаалдаг хувийн эрх чөлөөний эрх юм. Иргэний нийтлэг эрх нь гэр бүл болох, хэл сонгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх юм. Иргэний эрх нь үндсэн хууль болон иргэний хуульд баталгаажсан байдаг. Иргэний хууль гэдэг нь иргэдийн бие биедээ чиглэсэн эрх, үүргийн нэгдэл юм. Иргэний хуулиар ихэвчлэн гэрлэлт, өв залгамжлалын журмыг тогтоодог. Иргэний хууль нь хүний эрхийг шууд хамгаалах шаардлагагүй. Жишээлбэл, иргэний хуулинд гэрлэлт нь хайр сэтгэл, хамтдаа амьдрах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлдэг гэж заасан байдаг. Гэвч энэ нь хүний эрх биш, харин иргэдийн харилцаа, энэ тохиолдолд гэрлэсэн хосуудын харилцаатай холбоотой.

⁶ https://www.conscourt.gov.mn/?page_id=842&lang=en

Монгол Улсын Иргэний хуулийн зорилт нь⁷ “эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино”. Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.

4.3 Хууль дүрэм, журам

Эрүүгийн хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн хууль зэрэг үндэсний хууль тогтоомжийн зэрэгцээ тодорхой эрхийг нарийвчлан тусгасан төрийн дүрэм журам бас байдаг. Тухайлбал, ажлын байрны аюулгүй байдлын наад захын дүрмийг тодорхойлсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь үүний нэг жишээ юм.


5. Соёлын болон нийгмийн хэм хэмжээ болон үнэт зүйлс

Соёлын хэм хэмжээ болон үнэт зүйлс нь эрхүүдийн шатлалын суурь болдог бөгөөд хуулийг дээдлэн сахиж байна уу, үгүй юу гэдгийг тодорхойлж байдаг. Заримдаа эрхийг мөрдөхөд ашиг сонирхлын зөрчил үүсдэг. Жишээ нь: Бүх иргэдийнхээ хөгжих эрхийг зарим улс орны засгийн газар хэрэгжүүлж чаддаггүй. Энэ нь тухайн засгийн газрын улс төрийн өөр өөр нам эвслийн зүгээс улс орны бүс нутгийн хооронд болон үндэстэн ястны хооронд баялгийг шударга хуваарилах асуудалд хандах хандлагатай холбоотой.

Зарим үндэстэн ястан болон үндэстний цөөнх тухайн нийгмийн зонхилох бүлгээс ертөнцийг үзэх ялгаатай үзэл бодолтой байж болно. Тухайлбал, ихэнх хүмүүс хүний амьд явах эрхийг адгуусны амьд явах эрхээс дээгүүр үнэлдэг ч энэ нь түгээмэл үзэл бодол биш юм.

6. Хүний эрхийн шатлал

Эрхийн пирамидыг дараах байдлаар байгуулж болно:



Эрхүүдийн энэхүү шатлал нь Европын хуулийн тогтолцоонд суурилж, ихэнх улс орон хүлээн зөвшөөрсөн ч зарим улс орон хүлээн зөвшөөрөөгүй байдаг. Тухайлбал, исламын зарим улс оронд шашны хууль нь пирамидын оройд байрласан байдаг. Зарим оронд уламжлалт ёс заншилд суурилсан “ерөнхий хууль” байдаг.

⁷ <https://www.legalinfo.mn/law/details/299?lawid=299>

Дасгал 2.1.2 Би юу хийх ёстой вэ?



Зорилго

- Эрхийг үүрэг, хариуцлага дагалддаг болохыг ойлгох
- Улс орныхоо сайн иргэн, нутаг усныхаа сайн гишүүн байх үүрэг, хариуцлагаа ойлгох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд (Хувилбар А), Залуучууд болон насанд хүрэгчид (Хувилбар Б)



Хугацаа

90 минут



Суудал зохион байгуулалт

5 ширээний ард багаараа суух



Ашиглах материал

- Хүүхдийн эрхийг илэрхийлсэн 10 зураг (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.1 А, Дасгал 2.2.1)
- 10 ширхэг самбарын үзэг, 10 ширхэг самбарын цаас
- 1-2 цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.2.1 А: Хүүхдийн эрхийг илэрхийлсэн зурагт карт (Хувилбар А)

2.1.2 А: Багийн ажилд зориулсан асуултууд : Эрх болон үүрэг хариуцлага (Хувилбар Б)

Нэмэлт мэдээлэл: Эрх болон үүрэг хариуцлага



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Таны гэрт хулгай орвол та юу хийх вэ? – 10 минут

Хувилбар А: Хүүхэд болон залуучууд

1. Хүүхдийн эрхийн зурагт картыг тарааж өгөх – 10 минут

2. Багийн ажил: Хүүхдийн эрх бүр дээр 2 үүрэг, хариуцлага – 40 минут

Хувилбар Б: Залуучууд болон насанд хүрэгчид

1. Баг зохион байгуулах – 20 минут
2. Эрх болон үүрэг хариуцлагын талаар багуудын танилцуулга – 30 минут
3. Эрх болон үүрэг хариуцлагын талаар ярилцах – 25 минут
4. Дүгнэлт – 5 минут

Алхам 1. Таны гэрт хулгай орвол та юу хийх вэ? – 10 минут

Оролцогчдоос дараах асуултыг асуугаарай. Танай хөршийнд хулгай орж байхыг чи харлаа. Чи юу хийх вэ? Зарим хариултыг сонссоны дараа нийгэмд амар тайван, аюулгүй байдлыг хадгалахыг хүсэж байвал бүх хүн бие биедээ туслах ёстой гэдгийг тайлбарлаарай. Нийгмийн гишүүн бүр аюулгүй аж төрөх эрхтэй. Аюулгүй байдал нь түүнийг хангахад чиглэсэн хувь хүний хариуцлагатай холбоотой. Энэ нь та бусдад хор хохирол учруулахгүй, бусдын төлөө санаа тавина гэсэн үг юм.

Хувилбар А: Хүүхэд болон Залуучууд

Алхам 2. Хүүхдийн эрхийн зурагт картыг тарааж өгөх – 10 минут

Бүлгийг 10 жижиг багт хуваана (нэг ширээнд 2 баг суух). Багуудад хүүхдийн эрхийн зурагт карт, самбарын цаас, самбарын үзэг тарааж өгнө (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.1 А). Картуудыг өмнөх дасгалд хэрэглэсэн бол зургуудыг санаж байгаа эсэхийг асууна. Хэрвээ тэд хүүхдийн эрхээ сайн санахгүй байвал тэдгээр 10 эрхийг нэг нэгээр нь тайлбарлаж сануулна. Оролцогчид эрхээ өөрсдөө сайн санаж байвал самбарын цаасан дээр шууд нааж байрлуулна.

Алхам 3. Багийн ажил: Хүүхдийн эрх бүр дээр 2 үүрэг, хариуцлага – 40 минут

Багуудыг зураг бүрийн доор 2 жагсаалт гаргахыг хүснэ. (1) Зурган дээр байгаа эрхүүдтэй холбоотойгоор хүлээх үүрэг, хариуцлагыг жагсаан бичих. (2) Зурган дээр байгаа эрхтэй холбоотой бусад хүмүүсийн хүлээх үүрэг, хариуцлагыг жагсаан бичнэ. Жагсаалт урт байх хэрэггүй. Багийн гишүүд нэг эрхтэй холбоотой хамгийн багадаа 2 үүрэг хариуцлага гаргаж ирэхэд болно. Сургагч багш өрөөний дунд алхаж зарим нэг санаа хэлнэ. 15 минутын дараа багийн гишүүд ажлаа дуусгаад гаргасан жагсаалтаа ханан дэр нааж байрлуулна (Бичиг үсгийн чадвар багатай хүүхэд, залуучууд байвал санаагаа зургаар илэрхийлэн зурж болно).

Хувилбар Б: Залуучууд болон насанд хүрэгчид

Алхам 2. Баг зохион байгуулах – 20 минут

Оролцогчдыг 5 багт хувааж баг бүрт асуулт (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.2 А), самбарын үзэг, самбарын цаас тарааж өгнө. Оролцогчид 15 минутад багтааж хариултаа бичнэ. Багийн гишүүд асуултаа зөв ойлгосон эсэхийг нягтлаарай. Сургагч багш бичиг үсгийн чадвар багатай оролцогчдод асуултыг уншиж тайлбарлаж өгөөрэй.

Алхам 3. Эрх болон үүрэг хариуцлагын талаар багуудын танилцуулга – 30 минут

Багийн гишүүд 5 минутын хугацаанд багийн ажлаа бусад багт танилцуулна.

2 хувилбарыг үргэлжлүүлэх нь



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Алхам 3-ын танилцуулга нь зөв хариулт өгөхөд чиглэхээс илүү энэхүү асуудлыг хэлэлцэхэд оролцогчдыг өдөөж өгөхөд оршино. Бүх хариулт төстэй байх болно. Хүн нэг бүр бусдыг сонсох, бусдын итгэл үнэмшлийг хүндлэх, шударга байх хариуцлага хүлээнэ. Өөрсдийнх нь эрх эсвэл бусад хүний эрх зөрчигдөх тохиолдолд энэхүү зөрчилтэй тэмцэх хариуцлага хүлээх болно гэдгийг онцлох нь чухал. Эрх, үүргүүдийн талаарх нэмэлт мэдээллээс дэлгэрүүлж уншаарай.

Алхам 4. Эрх болон үүрэг хариуцлагын талаар ярилцах – 25 минут

Багийн ажлын дараа дараах асуултын дагуу ажлын үр дүнг хэлэлцээрэй:

- Аль эрх нь тодорхой үүрэг хариуцлагатай холбоотой байна вэ?
- Ямар эрх дээр үүрэг хариуцлага гаргахад хүндрэлтэй байсан бэ?
- Үүргээ биелүүлэх нь хялбар байх уу эсвэл хэцүү байх уу? Яагаад ?

Алхам 5. Дүгнэлт - 5 минут

Дараах санааг тайлбарлаж, дүгнэлт хийгээрэй.

- Эрхийг үүрэг хариуцлага дагалддаг.
- Бид мэдээлэл цуглуулж, өөрсдийн эрхээ тодруулах үүрэгтэй.
- Хүн бүр эрхтэй юм чинь хэлэх гэснээ хэлж, хийнэ гэснээ хийж болохгүй. Заримдаа энэ нь хэн нэгнийг хохироож, сөрөг үр дагавар авчирдаг.
- Бид өөрсдийн төдийгүй бусдын эрхийг хамгаалах хариуцлага хүлээдэг.



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.1.2 А: Багийн ажилд зориулсан асуултууд: Эрх болон үүрэг хариуцлага⁸

Зааварчилгаа: Тодорхой эрх, түүнд харгалзах үүргүүдийн талаар багаараа ярилцахын тулд 5 эрхийг сонгон ав. Оролцогчдын хувийн амьдралыг тусгах байдлаар нөхцөлийг өөрчилж болно.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

Та өөрийн амьдардаг орон нутгийн хүмүүстэй бага төсөвт багтааж зарим нэг үйлчилгээг сайжруулах талаар санал бодлоо солилцох уулзалтад оролцож байна. Танд бодол саналаа чөлөөтэй хэлэх эрх бий.

- Таны яаж ярих, юуны тухай ярих нь ямар үүрэг хариуцлагатай холбоотой вэ?
- Таныг үзэл бодлоо хэлэхэд бусад хүмүүс ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?
- Бусад хүмүүс санал бодлоо хэлэхэд та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Иргэний харьяалалтай байх эрх

Та саяхан аав/ээж болсон гэж төсөөлье.

- Хүүхдийн иргэний харьяалалтай байх эрхтэй холбоотойгоор та аав/ээжийн хувьд ямар хариуцлага хүлээх вэ?
- Хүүхдийнхээ өмнө өөр ямар ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Боолчлол, албадан хөдөлмөрөөс ангид байх эрх

Та хэн нэгнийг сумынхаа нэг охинтой их л сэжигтэй байдлаар ярилцаж байхыг харлаа гэж бодъё. Тэр охин их л хэцүү байдалтай харагдаж байна. Охин хэсэг эргэлзсэн байдалтай байснаа тэр хүнийг дагаад явжээ.

- Охины өмнө та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ? Та юу хийх вэ?

Танай гэрийн ойролцоо залуухан гэрийн үйлчлэгч амьдардаг гэж бодъё. Тэр дандаа л гунигтай харагддаг. Заримдаа түүний гар хөхөрсөн харагддаг.

- Охины өмнө та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Санал өгөх эрх

Та сонгуульд саналаа өгөх гэж байна гэж төсөөлье. 5 нэр дэвшигчээс та нэг л хүнд саналаа өгнө.

- Санал өгөхөд та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Зарим найз нөхөд чинь таны сонголттой санал нийлэхгүй байна гэж бодъё. Таны санал өгөх эрхтэй холбоотойгоор тэд ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

- Хэрвээ та найз нар, хөршүүд болон орон нутгийн бусад хүмүүсийн саналыг зөвшөөрөхгүй байвал тэдний санал өгөх эрхтэй холбоотойгоор ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

⁸ We the people by Centre of Civic Education, Exercise: What responsibilities accompany our rights?, <http://www.civiced.org>.

Шударга хандлага хүртэх эрх

Хэн нэгэн таныг буруу үйл ажиллагаанд (хулгай, хууль зөрчсөн ямар нэг үйлдэл) буруутгасан гэж бодъё

- Тэр хүн таны өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Та бусдыг буруу зүйл хийсэнд буруутгасан гэж бодъё.

- Та тэр хүмүүсийн өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Шашин шүтэх эрх

Та ямар нэг шашин шүтдэг гэж бодъё. Өөрийнхөө амьдардаг газартаа сүм, хийд, цуглаанд явдаг.

- Шүтдэг шашныхаа итгэл үнэмшлийг илэрхийлэхэд танд ямар үүрэг хариуцлага ноодох вэ?

Таны эргэн тойронд амьдарч байгаа хүмүүс өөр шашин шүтдэг, зарим нь шүтдэггүй хүмүүс байж болно.

- Тэд таны шашин шүтэх эрхтэй холбоотойгоор ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?
- Шашин шүтэх, эс шүтэх бусад хүмүүсийн эрхийг хамгаалахад та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх

Танай орон нутгийн иргэд олон нийтийн нэгэн арга хэмжээ төлөвлөж байна.

- Таны нас, хүйс, үндэс угсааг харгалзахгүйгээр танд шударга хандахад тэд ямар үүрэг хариуцлага хүлээж болох вэ?

Та энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахад тусалж байна гэж бодъё.

- Бусад хүмүүсийн өмнө та ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Хань ижлээ сонгох, гэрлэх эрх

Танай аав ээж чамтай суух хүнийг сонгосон, харин чи тэр хүнтэй гэрлэхийг хүсэхгүй байна гэж бодъё.

- Чи эцэг эхийнхээ өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?
- Тэд чиний өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?

Хуулийн дагуу хамгаалагдах эрх

Засгийн газраас дэд бүтцийн өөрчлөлт хийхээр болж таны амьдардаг орон нутгийн хүмүүсийг өөр газар нүүхийг шаардсан байна гэж төсөөлье.

- Засгийн газар таны болон танай орон нутгийн иргэдийн өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх ёстой вэ?

Танай хөрш нөлөө бүхий хүн бөгөөд орон нутгийн бусад иргэдээс илүү их хөнгөлөлт эдэлдэг болохыг та мэджээ.

- Та орон нутгийнхаа бусад иргэдийн өмнө ямар үүрэг хариуцлага хүлээх вэ?



Нэмэлт мэдээлэл: Эрх болон үүрэг хариуцлага

Бид бүгд тодорхой эрх эдлэх ёстой гэдгээ мэддэг. Жишээ нь: Аж амьдралаа тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх, сурч боловсрох, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх гэх мэт. Бид өөрийн итгэл үнэмшилтэй байхыг хүсдэг. Бид ямар нэгэн тамлан зовоох үйлдэл, ялгаварлалаас ангид байхыг хүсдэг. Түүнчлэн өмч эзэмшиж, эд хөрөнгөтэй байж, хүссэн газраараа аялахыг хүсдэг. Сонгуулийн насны иргэд сонгуульд саналаа өгөхийг хүсдэг.

Хүн бүр ижил тэгш эрхтэй гэж заасан нь таны эдлэх эрхийг бусад хүмүүс бас эдлэх ёстой гэсэн үг. Ийм учраас хүний эрх болон хүүхдийн эрхийн хамгаалал нь бүх хүний сонирхол эрх ашигт нийцдэг. Бид эдгээр эрхээ эдлэхийн хамт хариуцлага хүлээх үүрэгтэй. Энэ нь зөвхөн нэг талт нөхцөл биш. Хүмүүс бие биеийнхээ өмнө хариуцлага хүлээж, бие биеийнхээ эрхийг хүндлэх ёстой.

Иргэний хувьд та дараах үүрэг хариуцлагыг хүлээнэ:

- Өөрийн эрхийг мэдэж, энэ талаар мэдээлэл цуглуулах
- Бусдыг сонсох
- Бие биеийнхээ үзэл бодлыг хүндлэх
- Бусдын итгэл үнэмшил, зан үйлийг хүндлэх
- Санал өгөх эрхээ эдлэх
- Шүүх гэж яарахын өмнө үнэнийг олж мэдэх
- Эрх зөрчигдсөн үед арга хэмжээ авах
- Хүний эрхийн зөрчилтэй тэмцэхэд бусдыг өдөөх

Сэдэв 2.2 Хүүхдийн эрх



Агуулга

Энэ сэдвийн хүрээнд НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, хүүхдийн эрхийн асуудлаар Монгол улсад баримталж буй бодлого, мөрдөж буй хууль дүрмийн дагуу хүүхдийн үндсэн эрхийг танилцуулна. Хүүхдийн үндсэн эрхтэй танилцахын зэрэгцээ оролцогчид Монгол дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхдийн эрх зөрчигдөхөд хэнд, хаана хандах талаар авч үзнэ. Улс орнуудын хамгийн ихээр анхааралдаа авах ёстой гэж тодорхойлсон эрхийг илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.



Үндсэн мэдээлэл

- Хүүхдийн эрхийн зарчмууд нь дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрсөн зарчмууд юм.
- Бүх охид, хөвгүүд дараах эрхийг эдэлнэ хэмээн тунхаглан зарласан билээ. Үүнд:
 - Хүүхэд төрмөгцөө нэр авах, иргэний харьяалалтай байх
 - Эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх
 - Эрүүл хүнсээр хангагдах
 - Сурч боловсрох
 - Эрүүл мэндээ хамгаалуулах
 - Найз нөхдөө сонгох
 - Амрах, тоглох
 - Хүчирхийлэл, мөлжлөгийн аливаа хэлбэр, ялгаварлан гадуурхахаас хамгаалагдах
 - Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх
 - Шаардлагатай тохиолдолд онцгой асаргаа, тусламж дэмжлэг авах (дүрвэсэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд).
- Эрх эдлэхийн зэрэгцээ үүрэг хариуцлага хүлээдэг.
- Бусад хүмүүсийн эрхийг ойлгож хүндэлснээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх боломжтой.
- Засгийн газар, гэр бүл, орон нутаг хүүхдүүдийн эрхийг хамгаалж, тэдний сайн сайхан байдлыг хангах үүрэгтэй.



Дасгал

- 2.2.1 Надад эрх бий – Сандалтай бүжиг
- 2.2.2 Би өөрөө шийдвэрлэж чадна
- 2.2.3 Би өөрийнхөө эрхийг мэднэ
- 2.2.4 Хүүхдүүд ч мөн эрхтэй - Зурагт хуудас бүтээх аян



Холбогдох сэдвүүд

- 2.1 Хүн бүр эрхтэй
- 2.2 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх
- 4.2 Хүүхдийн хөдөлмөр гэж юу вэ?
- 11.2 Хөдөлмөрлөх эрх

Дасгал 2.2.1 Надад эрх бий – Сандалтай бүжиг



Зорилго

Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох



Зорилтот бүлэг

Хүүхдүүд



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Хүн бүрт нэг сандал байхаар сандлаа тойруулан байрлуулна. Дундуур нь явах зайтай сандлаа байрлуулаарай.



Ашиглах материал

- Хөгжим, чанга яригч (Хүүхдүүдийн сайн мэддэг дуртай дуу, ая)
- 10 зурагт карт (Сургалтын Хэрэглэгдэхүүн 2.2.1 А)
- Цаасан скоч
- Хэрвээ боломжтой бол 5-10 минутын хугацаатай хүүхдийн эрхийн чиглэлээр хийсэн дүрс бичлэг



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.2.1.А: Хүүхдийн эрхийг илэрхийлсэн зурагт карт

Нэмэлт мэдээлэл: Монгол улс дахь хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Сандалтай бүжгээ эхлэх – 10 минут
2. Сандалтай бүжгээ үргэлжлүүлэх – 25 минут
3. Хүүхдийн эрхийн талаар хэлэлцэх – 25 минут
4. Дүгнэлт – 5 минут

Алхам 1. Сандалтай бүжгээ эхлэх – 10 минут

Хүүхдийн эрхийн талаар ярилцаж, сандалтай аяллаас дасгалаа эхэлнэ гэж тайлбарлана. Оролцогчдыг суухыг урьж, хүүхдийн эрхийг дүрсэлсэн 10 картын (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.1 А) нүүрэн талыг нь доош харуулж тавина. Тоглоомын дүрмийг тайлбарлана:

- Бүгд босож, тойргоос хоёр сандал хураана.
- Хөгжим дуугарахад оролцогчид хурдан хэмнэлээр тойргоор аялна.
- Хөгжим зогсонгуут бүгд сууна.
- Сандал хүрэлцэхгүй тул хоёр хүн сандалгүй хоцрох болно.
- Энэ хоёр хүн шалан дээрээс нэг нэг зураг сонгож, түүнийгээ эргүүлж, юуны тухай зураг болохыг тайлбарлаж, гэр бүл болон нийгэмд энэхүү эрх хэрэгжихэд охид, хөвгүүдийн хувьд ямар асуудал бэрхшээл байж болохыг хэлнэ.
- Харин хоёр оролцогч зургаа тайлбарлаж чадахгүй байвал бусад оролцогчид тусалж болно. Зургийг товч ярилцсаны дараа хананд байрлуулна.

Тоглоомоо эхэлж, нэг тойрог тоглоорой. Шаардлагатай бол дүрмийг дахин тайлбарлаж болно.

Алхам 2. Сандалтай бүжгээ үргэлжлүүлэх -25 минут

Хоёр сандал хураагаад, дахин хөгжмөө сонгож, тойргоор аялах аяллаа үргэлжлүүлнэ. Бүх зургийг тайлбарлаж дуустал тоглоомыг үргэлжлүүлнэ.

Алхам 3. Хүүхдийн эрхийн талаар хэлэлцэх -20 минут

Бүгд суудалдаа сууж эсвэл босож ханан дээрх зургуудыг харна.

Дараах асуултыг асууна:

- Эдгээр зургууд юуны тухай өгүүлж байна вэ?
- Зургууд хоорондоо холбоотой юм шиг санагдаж байна уу? Тийм бол ямар холбоотой байна вэ?
- Эдгээр нөхцөлүүдээс танд аль нь тулгарч байсан бэ?
- Харин аль зүйл нь танд тохиолдож байгаагүй вэ? Үгүй бол яагаад?
- Хүүхдийн эрхийн талаар та юу мэдэх вэ?

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын талаар танилцуулж тайлбарлана. “Нэмэлт мэдээлэл” хэсгээс дэлгэрүүлж үзээрэй. Үүний дараа багууд доорх сэдвийн дагуу ярилцана.

- Яг одоо чи хүүхдийн эрхээс аль эрхийг нь эдлэхийг хүсэж байна вэ? Яагаад?



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хүүхдийн эрхийн талаарх богино хэмжээний дүрс бичлэг үзүүлж, түүнийг сургалтын хэрэглэгдэхүүний хувьд ашиглаж болно. Жишээлбэл, Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас гаргасан дүрс бичлэг. <https://www.youtube.com/watch?v=fjKuUy2teUs> (2.34 минут) (Мөн НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан дүрс бичлэгүүд байж болно)




Алхам 4. Дүгнэлт – 5 минут

Хүүхдийн 10 эрхийн талаар товч дүгнэж, яг одоо хүүхдүүд ямар эрхийг, яагаад эдэлмээр байгаа талаар ярилцана (Алхам 3). Мөн амьдарч байгаа орон нутагт нь шилжин ирсэн, яс үндэс, шашин шүтлэг, нийгэм эдийн засгийн байдлаараа бусдаас ялгаатай хүүхдүүдэд зайлшгүй анхаарал тавих шаардлагатай гэдгийг онцлон тайлбарлаж ойлгуулна.



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.1 А: Хүүхдийн эрхийг илэрхийлсэн зурагт карт


Зааварчилгаа: Дараах 10 зургийг А4 эсвэл А3 хэмжээтэй цаасан дээр хувилаарай.




1. Хүүхэд төрмөгцөө нэр авах, иргэний харьяалалтай байх эрх



2. Эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх эрх




3. Эрүүл хоол хүнс хэрэглэх эрх



4. Сурч боловсрох эрх




5. Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх



6. Найз нөхдөө сонгох эрх




7. Амрах, тоглох эрх



8. Бүх төрлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, мөлжлөгөөс хамгаалагдах эрх



9. Өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх



10. Онцгой халамж, тусламж авах эрх



Нэмэлт мэдээлэл: Монгол улс дахь хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал⁹:

Бүх хүмүүс, хүүхэд, насанд хүрэгчид хүний эрхийг эдлэх эрхтэй. Гэвч хүүхдийн онцгой хэрэгцээ, эмзэг байдлыг харгалзан хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Хүүхдийн эрхийг хамгаалах талаар олон улсын хэмжээнд мөрдөгддөг хэд хэдэн хууль байдаг. Хүүхдийн эрхийг хамгаалахаар улс орон бүр мөрдөн хэрэгжүүлдэг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц 1989 оны 11 дүгээр сард батлагдсан бөгөөд энэхүү бичиг баримт нь дэлхийн бүх хүүхдүүдэд хамаарна гэж заасан байдаг. Тус конвенцод 196 орон¹⁰ нэгдсэн байдаг. Монгол Улс Хүүхдийн Эрхийн тухай Конвенцод 1990 онд нэгдэн орж, улмаар конвенцын үзэл санааг үндэсний хууль тогтоомжид тусгах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Үндэсний хуулинд өөрөөр заагаагүй бол 18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд гэж үзнэ гэж Хүүхдийн эрхийн конвенцод заасан байдаг.

Хүүхдийн эрхийн конвенц хүүхдийн дараах эрхүүдийг соёрхон баталсан:

- Тэгш эрхтэй байх
- Хайр халамж хүртэх
- Эрүүл хоол хүнсээр хангагдах
- Сургуульд суралцах
- Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх
- Тоглох
- Өөрийн найз нөхдийг сонгох
- Бэлгийн хүчирхийллээс ангид байх
- Хөдөлмөр эрхлэхгүй байх.

Хүүхдийн эрхийн тухай конвенц 54 зүйлтэй, зүйл бүр эрхийн өөр өөр төрлийн талаар өгүүлдэг. Бүх эрхүүд үндсэн 4 төрөлд хуваагддаг. Үүнд:

- **Эсэн мэнд амьдрах эрх** нь хүүхдийн эрүүл өсөн торниход хэрэгтэй амьдралын суурь хэрэгцээг хангах талаар өгүүлдэг. Үүнд амьжиргааны хангамж, орон байр, тэжээллэг хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээг зохих түвшинд хангах талаар өгүүлнэ.
- **Хөгжих эрх** нь өөрийн нөөц боломжийг бүрэн дүүрэн нээхэд хүүхдэд хэрэгтэй зүйлийн талаар өгүүлнэ. Тухайлбал, сурч боловсрох, тоглох, чөлөөт цагаа зөв өнгөрөөх, соёлын арга хэмжээнд оролцох, мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх эс шүтэх эрхүүд багтана.
- **Хамгаалагдах эрх** нь хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, хараа хяналтгүй байдал, мөлжлөгөөс хамгаалах тухай өгүүлнэ. Энэ нь шилжин суурьшсан хүүхдүүдэд үзүүлэх онцгой халамж, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, зэвсэгт мөргөлдөөнд оролцох, хүүхдийн хөдөлмөрийг мөлжих, хар тамхи, мансуурал, бэлгийн мөлжлөгт өртөхөөс хамгаалах талаар авч үздэг.
- **Оролцох эрх** нь хүүхдийг өөрийн орон нутаг, улс орны амьдралд идэвхтэй оролцох боломж олгодог. Хүүхдийг өөрийн амьдралд хамааралтай асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөгөөр хангах, өөрийн үзэл бодлоороо тайван чөлөөтэй нэгдэх асуудлууд багтана. Хүүхдүүдийн чадавх өсөхийн хэрээр нийгмийн амьдралд оролцох боломж нь нэмэгдэж, бие хүний хувьд ирээдүйн амьдралд бэлтгэгддэг.

⁹ UNICEF. See more at: https://www.unicef.org/crc/index_30177.html.

¹⁰ https://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-11&chapter=4&clang=en [accessed 24 October 2019].

Монгол Улс дахь хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал¹¹

Монгол Улс хүүхдийн язгуур эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс хамгаалах, хангахтай холбоотой олон улсын гэрээ конвенцуудад нэгдэн, тэдгээрийн үзэл санааг үндэсний хуульд тусгах чиглэлээр дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Олон улсын гэрээ, конвенцүүд	Монгол Улсын хууль, тогтоомжууд
• 1924 он “Хүүхдийн эрхийн тухай Женевийн тунхаглал” • 1959 он 1 сарын 20-ны өдрийн Ерөнхий Ассамблейн Хүүхдийн эрхийн тунхаглал • 1973 он Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц • 1989 он 11 сарын 20-ны өдрийн Хүүхдийн эрхийн тухай Конвенц • 1999 он Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц • 2003 он Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол • 2003 он Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол • 2015 он Мэдээлэл хүргүүлэх журмын тухай НҮБ-ын нэмэлт протокол	• 1992 он Монгол Улсын Үндсэн хууль • 1996 он Гэр бүлийн тухай хууль • 1999 он Хөдөлмөрийн тухай хууль • 2002 он Боловсролын тухай хууль • 2011 он Эрүүл мэндийн тухай хууль • 2012 он Нийгмийн халамжийн тухай хууль • 2015 он Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) • 2015 он Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль • 2016 он Хүүхэд хамгааллын тухай хууль • 2016 он Хүүхдийн эрхийн тухай хууль • 2016 он Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль • 2016 он Эрүүл ахуйн тухай хууль • 2017 он Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) • 2016 он Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль • 2017 он Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) • 2017 он Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль • 2017 он Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021) ЗГ-ын 270 дугаар тогтоол

Монгол улс хүүхдийг үл хайхрах байдал, хүчирхийлэл, дарамт мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалахыг хуульчилсан 49 дэх орон болсон. Хуулинд Хүүхдийн эрхийг хамгаалахад дараах зарчмыг баримтална хэмээн заасан¹²:

1. Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;
2. Төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;
3. Хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
4. Хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;
5. Хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах.

Хүүхдийн эрхийн тухай хууль нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, түүнчлэн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн болон орон нутгийн байгууллага, хүүхдийн асуудал хариуцсан үндэсний болон орон нутгийн зөвлөл, олон нийтийн бусад байгууллага, эцэг эх, иргэд, хуулийн этгээдийн бүрэн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Үүний хамт Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа юм.

¹¹ Save the Children, Child Rights Situation in Mongolia 2018, chapter 3A, pp. 49-75.

¹² <https://www.legalinfo.mn/law/details/11710?lawid=11710>.

Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль боловсруулагдаж байгаатай холбоотой 2015 оноос хэд хэдэн байгууллага, алба шинээр байгуулагдаж, бүтцийн өөрчлөлт хийгдсэн. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Хүүхдийн тусламжийн утас - 108
- Түр хамгаалах байр
- Сургалт, судалгаа, мэдээллийн төв
- Монголын нийгмийн ажилтны ёс зүйн Зөвлөл
- “Өнөр бүл” төв
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэмжлэгтэйгээр Багахангай дүүрэгт байгуулсан хараа хяналтгүй хүүхдийг хамгаалах, гэр бүлд нь эргэн нэгтгэх төв
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс
- Нэг цэгийн үйлчилгээ
- Насанд хүрээгүй хууль зөрчигч, гэмт хэргийн хохирогч, гэрчтэй ажиллах Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах хамтарсан баг

Хүүхэд хамгаалах тухай хуулиар хүүхэд хамгаалал гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй байна хэмээн заажээ. Уг хуулиар хүүхдийн эрхийг хэрэгжүүлэгч албан ёсны субъектүүд болох нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн элчийн үүрэг, чиглэлийг хуульчилсан. Нийгмийн бүх орчинд хүүхдийг шийтгэхийг хориглосон.

2017, 2019 онуудад хүүхдийн эрхийн улсын 70 байцаагч бэлтгэгдэж, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий ажилтан нь хүүхдийн эрхийн улсын байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагын ажилтнууд байхаар зааж өгсөн. Тухайлбал, Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8 дахь хэсэг, 10.23 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Түүнээс гадна Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, хоол тэжээл, хөгжил, хамгааллын чиглэлээр үндэсний хөтөлбөр, дүрэм, стандартуудыг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал:

1. Хоол, тэжээл, хүнсний аюулгүй байдлын тухай бодлого (2016-2025 он)
2. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021 он)
3. Эх хүүхдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн хөтөлбөр (2017-2021 он)
4. Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр (2018-2020 он)
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017-2022 он)
6. “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” хөтөлбөр 2018-2022 он

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл 2018 оны 03 дугаар тогтоолоор салбар бүр болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус бүх шатны байгууллагуудын мөрдөх “Хүүхэд хамгааллын бодлого, чиглэл” баталж, боловсролын салбарт “хүүхэд хамгааллын бодлого, дүрэм”-ийг баталсан. Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар 19 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний 13 төв байгуулагдан ажиллаж байна. Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүчирхийллийн нийт хохирогчдын 80 гаруй хувь нь 0-18 хүртэлх насны хүүхэд байна¹³.

¹³ ХНХА, ГБХЗХГ

Дасгал 2.2.2 Би өөрөө шийдвэрлэж чадна



Зорилго

- Эрхийг үүрэг хариуцлага дагалддаг гэдгийг ойлгох
- Янз бүрийн хүмүүсийн эрх хоорондоо зөрчилдөж болохыг ойлгох
- Зөрчлийг шийдвэрлэх боломжит хувилбаруудын талаар эргэцүүлэх



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Ширээг тойрог хэлбэрээр засах



Ашиглах материал

- Зурагт картыг олшруулах (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.2 А), баг бүрт нэг ширхэг
- Өнгийн харандаа
- Цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.2.2 А: Зурагт карт



Сургалт зохион байгуулах алхмууд ¹⁴

1. Эрхтэй холбоотой зөрчлүүд үүсэж болох талаар мэдээлэл өгөх – 5 минут
2. Багийн ажил – 15 минут
3. Багийн ажлын танилцуулга, хэлэлцүүлэг – 30 минут
4. Дүгнэлт – 5 минут

¹⁴ It's Only Right! A Practical Guide to Learn More about the Convention on the Rights of the Child by Susan Fountain (UNICEF: New York, 1993), Activity 6: Rights in Conflict Cartoons, p.39 - 42.

Алхам 1. Эрхтэй холбоотой зөрчлүүд үүсэж болох талаар мэдээлэл өгөх – 5 минут

Зарим тохиолдолд нэг хүний эрх нөгөө хүний эрхтэй зөрчилдөж болохыг тайлбарлаарай. Тухайлбал, нэг хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэн хэн нэгний хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, арьс өнгө, нийгмийн байдлаар доромжилсон санаа хэлж болно. Гэтэл нөгөө хүн алагчлан үзэхээс ангид байх эрхтэй учраас мэдээж дургүйцнэ. Үүний дүнд зөрчил үүснэ.

Заримдаа хүмүүс зарим эрхийн талаар өөр өөр тайлбар өгдөг. Жишээ нь: Эцэг эхчүүд хүүхэд аливаа хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй гэж үздэг хэрнээ хүүхдээ буруу зүйл хийвэл шийтгэж, загнаж, цохидог. Шийтгүүлсэн хүүхдэд дарамт, хүчирхийлэлд өртсөн гэсэн мэдрэмж төрж болно. Дасгалын явцад оролцогчид зөрчилтэй нөхцөл байдлын талаар эргэцүүлнэ.

Алхам 2. Багийн ажил – 15 минут

Оролцогчдыг 4-5 хүнтэй багт хуваана. Баг бүрт зурагт хуудсыг олшруулж өгнө (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.2 А). Хоёр зургийг ажиглаад зөрчлийг шийдвэрлэх арга замын талаар эргэцүүлэхийг санал болгоно. Баг бүр зурагт картын хоосон 4 нүдэнд зөрчлийг хэрхэн шийдвэрлэж болох талаар шийдлээ санал болгоно. Зураг нь гоё, сайхан байх шаардлагагүй. Хамгийн гол нь бодит нөхцөл байдал болон зөрчлийг шийдвэрлэж болох гарцыг олох нь чухал.

Алхам 3. Багийн ажлын танилцуулга, хэлэлцүүлэг – 30 минут

Бүх багийг өөрсдийн хийсэн ажлаа бусдадаа танилцуулахыг хүсээд дараах асуултын дагуу товч хэлэлцүүлэг өрнүүлээрэй:

- Шийдвэр гаргахад хэцүү байсан уу? Яагаад? Үгүй бол тайлбарлана уу?
- Багууд ижил шийдвэр гаргасан уу?
- Ямар шийдэл санал болгох бол? Яагаад?
- Ямар тохиолдолд аль аль тал хүссэн зүйлээ авч чадах вэ?
- Танд ийм зөрчилдөөнтэй нөхцөл тулгарч байсан уу? Тийм бол ямар арга хэмжээ авч байсан бэ?

Алхам 4. Дүгнэлт – 5 минут

Дараах санааг онцолж хэлэлцүүлгийн гол үр дүнг нэгтгэж дүгнээрэй:

- Эрхийг үүрэг, хариуцлага дагалддаг.
- Хэн нэгэн өөрийн хүссэн бүхнийг ярьж, хийж болдоггүй. Учир нь энэ нь өөр хүний эрхийг зөрчиж болно.
- Эрхээ эдэлж, эрхээ хамгаалахдаа бусдын эрх ашгийг хөндөж байна уу гэдгийг анхаарна.
- Бусад хүмүүсийн эрхийг ойлгож хүндлэх нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг шийдвэрлэхэд тусалдаг.




Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.2 А: Зурагт карт


Зааварчилгаа: Зургуудыг хувилаад баг бүрт өгнө. Зарим баг ижил зургууд авч болно.

Зураг 1: Ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй зөрчилдөх нь

Сургууль дээр нэгэн охин найздаа тарган махлаг охин өөрт нь огт таалагддаггүй, учир нь тарган хүмүүс тэнэг бас залхуу байдаг гэж хэлжээ.



Тэр хоёрын хажуугаар явж байсан охин бусдыг ингэж үнэлэх нь шударга биш гэж шүүмж хэлсэн охинд хэлнэ.




Зураг 2: Сурч боловсрох эрх, хангалттай эрүүл хүнсээр хангагдах эрхтэй зөрчилдөх нь

Шалгалтад бэлдэж байсан хүү өлсөж байна. Тэрээр оройн хоолондоо жаахан шөлтэй хоол идсэн учраас цадаагүй ажээ.



Ажил олдохгүй байгаа учраас хүүхдүүддээ хоол хүнс худалдан авч чадахгүй байгааг хүүгийн эцэг эх нь учирлана. Маш олон ажил олгогч хүүхдүүдээр ажил хийлгэдэг ч насанд хүрэгчдийг ажилд авдаггүй байна.



Зураг 3: Эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал, хайр халамжид байх эрх нь хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдлаас хамгаалагдах эрхтэй зөрчилдөх нь

Аав нь гэртээ дахин архи ууж ирээд ээжтэй нь хэрэлдэж эхлэв. Энэ байдал ойр ойрхон давтагдах болов.



Аав нь ээжийг нь зодоход хүүхдүүд маш их айж, уурлаж шаналдаг.



Дасгал 2.2.3 Би өөрийнхөө эрхийг мэднэ



Зорилго

- Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох
- Хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдолд тусламж хүсэх арга замаа мэдэх



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд (шаардлагатай бол өөр өөр баг болгох)



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

U - хэлбэртэй, эсвэл тойргоор дундуур нь хүн явах зайтай суух



Ашиглах материал

- Оролцогч бүрд 2-оос доошгүй цагаан цаас
- Өнгийн харандаа, самбарын үзэг, цаасан скоч
- Самбарын 10ш. цаас
- Хүүхдийн эрхийн 10 карт (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.2.1 А)



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.2.1 А: Хүүхдийн эрхийн карт (дасгал 2.2.1)

Нэмэлт мэдээлэл: Хүүхдийн эрх (дасгал 2.2.1)



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Оролцогчдоор хийх дуртай зүйл, дургүй зүйлийг зуруулах – 15 минут
2. Хүүхдийн эрх гэж юу вэ? – 10 минут
3. Зургуудыг хүүхдийн эрхийн карттай тохируулах – 10 минут
4. Хүүхдийн эрхийн зөрчил болон хамгааллын талаар ярилцах – 20 минут
5. Сэргээн санах тест – 5 минут

Бэлтгэл

Бүх оролцогчдод харагдахаар 10 ширхэг самбарын цаас хананд байрлуулаарай.

Алхам 1. Оролцогчдоор хийх дуртай зүйл, дургүй зүйлийг зуруулах – 15 минут

Оролцогчид өөрийн хийх дуртай зүйл, хийх гэж мөрөөддөг зүйл, мөн хийх дургүй, хийнэ гэхээс үзэн яддаг зүйлийн талаар ярилцана гэж тайлбарлана.

Тэдэнд А-4 хэмжээтэй 2 ширхэг цаас өгч, хоёр зураг зурахыг санал болгоно.

- Нэг цаасан дээр өөрт таалагддаг зүйлийг зурна. Энэ нь заавал өөрсдийнх нь хийж чаддаг зүйл байх албагүй. Оролцогчид өөрсдийн мөрөөддөг, хийхийг хүсдэг зүйлээ ч зурж болно.
- Нөгөө цаасан дээр таалагддаггүй зүйл эсвэл хийх дургүй, хийхийг хүсдэггүй зүйлийг зурна.

Зурсан зурагнууд нь гоё байх шаардлагагүй, гэхдээ тодорхой байх хэрэгтэй. Зураг нэг бүрийг зурахад 5 минутын хугацаа өгнө. Цагаа харж, дараагийн зургаа зурж эхлэхийг нь хэлнэ.

Алхам 2. Хүүхдийн эрх гэж юу вэ? – 10 минут

Оролцогчдоос хүүхдийн эрхийн талаар сонсож байсан эсэх, Монгол улсын хууль тогтоомжоор хүүхдийн ямар эрх хамгаалагдсан байдаг талаар асууна (Дасгал 2.2.1, Нэмэлт мэдээлэл "Хүүхдийн эрх" харах). Аль нэг эрхийг онцлохгүйгээр НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцын хүүхдийн эрхийн зарчмуудыг товч тайлбарлана. Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц болон Монгол улсын хууль тогтоомжид хүүхдийн ямар эрхүүд тусгагдсан талаар мэддэг эсэхийг асууна (Хэрвээ оролцогчид 2.2.1 дасгалыг ажилласан бол ямар эрх санаж байгааг асуух).

Хэрвээ оролцогчдын нэрлэсэн эрх хүүхдийн эрхийн 10 ширхэг зурагт карттай СХ 2.2.1 А тохирч байвал хананд өлгөсөн цаасан дээр наагаарай. Самбарын цаасан дээр нэг л зураг байрлуулна. Хэрвээ оролцогчид өөр эрх нэрлэхгүй, гэтэл зурагт картууд үлдсэн бол нэг нэгээр нь харуулаарай. Эдгээр эрх ямар утгатайг тайлбарлаад самбарын цаасан дээр нэмж байрлуулна.

Алхам 3. Зургуудыг хүүхдийн эрхийн карттай тохируулах – 10 минут

Оролцогчдыг зурсан зургуудаа хүүхдийн аль эрхтэй тохирч байна, түүнтэй нь хамт байрлуулахыг хүснэ. Жишээ нь: Сургуульдаа явах дуртай/дургүй байгаа сэдвээр зурсан бол хүүхдийн сурч боловсрох эрхийн зурагны хажууд байрлуулж болно. Зургаа хаана байрлуулахаа хараахан мэдэхгүй байвал гартаа бариад зогсож байна. Зургаа байрлуулахад 5 минутын хугацаа өгөөрэй.

Алхам 4. Хүүхдийн эрхийн зөрчил болон хамгааллын талаар ярилцах – 20 минут

Оролцогчдоос байрлуулсан зургийг дахин нэг харж, ямар нэг эрх дутуу байна уу үгүй юу гэж асууна. Дурдагдаагүй эрх байвал түүний талаар ярьж болно.

Зургаа хананд байрлуулаагүй хүн байгаа эсэхийг асууна. Зургаа байрлуулахад нь бусад оролцогчдоор туслуулж болно. Шаардлагатай бол чиглүүлж туслаарай. Хэрэв хэн нэг нь нисэгч эсвэл кино жүжигчин болох хүслээ зурсан байвал зургийг сурч боловсрох эрхийг илэрхийлсэн самбарын цаасан дээр байрлуулж болно. Учир нь нисэгч эсвэл жүжигчин болохын тулд боловсрол эзэмших, сурах хэрэгтэй. Зарим зургийг аль нэг эрхтэй тохируулах боломжгүй байж болно. Жишээ нь: бүтэн өдөр зурагт үзэх, гэрийн ажилд туслах, баяжих, үнэтэй зүйл худалдан авах г.м.

Оролцогчдыг суудалдаа эргэн суухыг урьж, дараах асуултаас хэлэлцүүлгээ эхлээрэй. Үүнд:

- Зурагт тусгагдсан эдгээр 10 эрхийг та эдэлдэг үү? Хэрэв үгүй бол аль эрхийг эдэлдэггүй вэ? Яагаад?
- Эрэгтэй эмэгтэй хүүхдүүд, өөр ястан үндэстэн, шашин шүтлэгтэй хүүхдүүдийн хооронд эрхээ эдлэхэд ялгаа байна уу? Баян, ядуу айлын хүүхдүүдийн хооронд ялгаа байж болох уу? Хэрэв тийм бол үүнийг яаж тайлбарлаж болох вэ? Энэ нь шударга гэж үү? Үгүй бол юу хийх ёстой вэ?
- Эдгээр эрх зөрчигдөж байгаа тохиолдолтой та таарч байсан уу? Хэрэв тийм бол, ямар эрхийг хэрхэн зөрчсөн бэ?

- Ийм тохиолдолд юу хийх вэ?

Монгол улсад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга), Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) зэрэг хүүхдийг хамгаалах олон хууль үйлчилдэг болохыг тайлбарлаарай. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд (насанд хүрэгчид) эрх зүйн онцгой хамгаалалтад байдаг.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Тухайн орон нутгийн хүүхдүүдийн нөхцөл байдалтай холбоотой хүүхдийн эрхүүдэд гол анхаарлаа төвлөрүүлээрэй. Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар оролцогчдын мэдлэгийг судалж, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд сургууль, орон нутагт хэрхэн дэмжлэг, тусламж авч болох талаар мэдээллийг өгөөрэй (Тухайлбал, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдлыг хэрхэн мэдээлэх, хэрхэн тусламж хүсэх).

Энэ хэсгээ дуусгахдаа дараах гол мэдээллийг өгөөрэй:

- Охид, хөвгүүд бүгд тэгш эрхтэй. Тэд хэн болох, төрсөн газар, нас, хүйс, гарал угсаа, шашин шүтлэг, баян, ядуу байхаас үл хамааран бүгд ижил тэгш эрхтэй.
- Зарим нэг ядуу улс оронд эсвэл гэр бүлд хүүхдүүд зарим нэг эрхийг эдэлж чадахгүй байж болох юм. Тэглээ гээд ядуу улс орны эсвэл ядуу гэр бүлийн хүүхдүүд цөөхөн эрхтэй гэсэн үг биш юм.
- Улс орон бүрийн засгийн газар нь бүх хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээдэг. Түүнчлэн гэр бүл, орон нутаг хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хангах үүрэгтэй.
- Монгол улсад мөн адил хүүхдийн эрхийг хамгаалах хуулиуд үйлчилдэг.
- Хүүхэд эрх нь зөрчигдөж байгаа болон бусад хүүхдийн эрх зөрчигдөж байгааг мэдсэн тохиолдолд Хүүхдийн тусламжийн “108” утас руу залгаж тусламж хүсэж болно. Хүүхдүүд та бүхэн өөрийн оршин суугаа сум, хорооны хамтарсан багийн ахлагч (Засаг дарга), цагдаа, нийгмийн ажилтанд хандаж болно. Сургуулийн орчинд ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтанд хандах хэрэгтэй.
- Насанд хүрсэн хүмүүс тухайлбал, хөрш айлын хүн, багш, эмч, нийгмийн ажилтан нь хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд Хүүхдийн тусламжийн 108 утас эсвэл цагдаагийн 102 утсанд заавал мэдээлэх үүрэгтэй.

Алхам 5. Сэргээн санах тест – 5 минут

Дасгалыг дуусгахдаа сэргээн санах богино сорил ажиллаарай:

- Оролцогчдоор эрхүүдийг нэрлүүлж, самбар дээр түргэн бичнэ. Бүх 10 эрхийг нэрлэтэл хүлээнэ. Эрхүүдээ сайн санаж байгаа оролцогчдыг сайшаагаарай. Хүүхдийн хамгийн чухал 10 эрхийг тогтоохыг сануулаарай.
- Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд дараах байгууллага, мэргэжилтэнд заавал хандаж, тусламж авахыг зөвлөөрэй. Тухайлбал:
 - ✓ Хүүхдийн тусламжийн “108” утас
 - ✓ Цагдаагийн “102” утас
 - ✓ Ангийн багш
 - ✓ Сургуулийн нийгмийн ажилтан
 - ✓ Дотуур байрны багш
 - ✓ Хүүхдийн эрхийн улсын байцаагч
 - ✓ Сум, хорооны хамтарсан баг (Засаг дарга, цагдаа, өрхийн эмч, нийгмийн ажилтан)
 - ✓ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс
 - ✓ Хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага
 - ✓ Цагдаагийн байгууллага
 - ✓ Аймаг, дүүргийн Өсвөр үеийн клиник

Дасгал 2.2.4 Хүүхдүүд ч мөн эрхтэй – Зурагт хуудас бүтээх аян



Зорилго

- Хүүхдийн үндсэн эрхийн талаар ойлголттой болох
- НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцын ач холбогдлыг ойлгох



Зорилтот бүлэг

Өсвөр насныхан, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

U- хэлбэртэй, эсвэл дундуур нь хүн явах зайтай тойргоор суух



Ашиглах материал

- 10 ширхэг самбарын цаас
- Цаасны цавуу 10 ширхэг
- Хуучин сонин, сэтгүүл эсвэл хүн бүрийн сайн мэддэг хүүхэлдэйн киноны баатруудын төрөл бүрийн ажил, үйлдэл хийж байгаа зураг
- Самбарын үзэг
- Соч
- 6 ширхэг хайч
- Дасгал 2.2.3-ын зургууд, эрх бүрд нэг зураг



Сургалтын хэрэглэгдэхүүн

Нэмэлт мэдээлэл: Монгол улс дахь хүүхдийн эрх ба хүүхэд хамгаалал (Дасгал 2.2.1)



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Би хүүхдэдээ юу хүсэж байна вэ? – 10 минут
2. Зурагт хуудас хийх – 20 минут
3. Хүүхдийн эрхийн талаар хэлэлцэх – 20 минут
4. Дүгнэлт – 10 минут

Бэлтгэл

Самбарын цаас бүр дээр дараах эрхийн нэгийг бичиж, хананд байрлуулна (өрөөний бүх ханыг ашиглана)

- Нэр, иргэний харьяалалтай байх эрх
- Эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал, хайр халамжид байх эрх
- Хангалттай эрүүл хүнсээр хангагдах эрх
- Сурч боловсрох эрх
- Эрүүл мэндээ хамгаалуулах эрх
- Найз нөхдөө сонгох эрх
- Амарч тоглох эрх
- Хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхлаас хамгаалагдах эрх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
- Шаардлагатай бол онцгой халамж, тусламж дэмжлэг авах эрх

Алхам 1. Би хүүхдэдээ юу хүсэж байна вэ? – 10 минут

Дасгалын зорилгоо товчхон танилцуулна. Оролцогчдоос эцэг эх, ах эгч, авга ах, нагац эгчийн хувьд хүүхдүүдэдээ юу хүсэж байдгийг асуугаарай. Дасгал 2.2.1-ийн Нэмэлт мэдээлэлд тусгагдсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол орны хүүхэд хамгааллын талаар ярьж, самбарын цаасанд дээр бичсэн үндсэн 10 эрхийг нэрлээрэй.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хэрвээ “Би өөрийнхөө эрхийг мэднэ” буюу дасгал 2.2.3-ыг хийсэн бол энэхүү дасгалын явцад зурсан зургуудыг ашиглаж болно. Эрх бүрт тохирсон нэг зураг сонгоно. Үүний дараа оролцогчдод зургийг нэг нэгээр нь харуулж, хүүхдийн аль эрхэд хамааралтай болохыг асууна. Оролцогчид хариулсны дараа зургийг хамааралтай самбарын цаасны дэргэд байрлуулна. Энэ нь үндсэн 10 эрхийг танилцуулах сонирхолтой арга юм.

Алхам 2. Зурагт хуудас хийх – 20 минут

Хүүхдийн үндсэн эрхийн тухай 10 зурагт хуудас танд хэрэгтэй байгаа гэдгийг тайлбарлана. Оролцогчдыг хос хосоор нь нэг баг болгоод хос бүрийг зурагт хуудас бүрт өөрийн хувь нэмрийг оруулахыг санал болгоно: уриа бичиж болно, зураг зурж болно, сонин, сэтгүүлээс зураг, текст авч нааж болно. Бусад багийн гишүүдийн хийж байгаа ажилтай уялдуулж ажиллана.

Алхам 3. Хүүхдийн эрхийн талаар хэлэлцэх – 20 минут

Зурагт хуудсуудаа хараад дараах асуултын дагуу дүгнэж ярилцана уу:

- Аль эрхэд зориулж зурах, наамал хийх нь хэцүү байсан бэ? Яагаад?
- Танай орон нутгийн хүүхдүүд дээр дурдсан бүх эрхийг эдэлж чаддаг уу? Үгүй бол ямар эрх зөрчигдөж байна вэ?

- Эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд дээрх эрхийг эдлэхэд ялгаа байх уу? Тийм бол, ийм ялгаа, тэгш бус байдал оршиж байдаг шалтгааныг та хэрхэн тайлбарлах вэ? Энэхүү ялгаа, тэгш бус байдлыг та хүлээн зөвшөөрөх үү эсвэл хүлээн зөвшөөрөхгүй юу?
- Гарал үүсэл болон шүтдэг шашин зэргээр хүүхэд эрхээ эдлэхэд нөлөөлж болох өөр ялгаатай байдал байдаг болов уу? Хэрвээ тийм бол ийм тэгш бус байдал, ялгаатай байдал оршиж байдаг шалтгааныг та тайлбарлаж чадах уу? Та үүнтэй хэр зэрэг санал нийлдэг вэ?
- “Бүх хүүхдүүд тэгш эрхтэй” гэсэн санааг та юу гэж ойлгодог вэ? Танай орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд эрхээ бүгд тэгш эдэлж байна уу? Хэрвээ үгүй бол яагаад? Хэрвээ хүүхдүүд эрхээ бүрэн эдэлж чадахгүй бол юу хийж болох вэ?
- Аль эрх нь хамгийн чухал гэж та бодож байна вэ? Яагаад?
- Эдгээр эрх зөрчигдсөн тохиолдлыг та мэдэх үү? Хэрэв тийм бол ямар эрхийг хэрхэн зөрчсөн бэ?
- Ийм тохиолдолд та юу хийх ёстой вэ?



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Орон нутгийн хүүхдүүдийн хувьд хамгийн чухал эрхэд хэлэлцүүлгээ төвлөрүүлээрэй. Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх оролцогчдын мэдлэг төсөөллийг судалж, орон нутагт нь хүүхдийн эрх зөрчигдөх тохиолдолд тэд хүүхдийг хэрхэн хамгаалж, түүнд тусалж болох талаар мэдээлэл өгөөрэй (Тухайлбал, ийм тохиолдлыг хэрхэн мэдээлж, хэрхэн тусалж болох вэ).

Дараах мэдээллээр дүгнэлтээ хийгээрэй:

- Охид, хөвгүүд бүгд тэгш эрхтэй. Тэд хэн болох, хаана төрсөн, нас, хүйс, гарал угсаа, шашин шүтлэг, баян, ядуу байхаас үл хамаарч бүгд ижил тэгш эрхтэй.
- Зарим нэг ядуу улс орон эсвэл ядуу гэр бүлд хүүхдүүд зарим нэг эрхийг эдэлж чадахгүй байж болох юм. Тэглээ гээд ядуу улс орны хүүхдүүд эсвэл ядуу гэр бүлийн хүүхдүүд цөөхөн эрхтэй гэсэн үг биш юм.
- Засгийн газар нь өөрийн улс орны хүүхэд бүр үндсэн эрхээ эдлэх явдлыг хангах үүрэг хариуцлага хүлээдэг. Гэр бүл болон орон нутаг ч мөн адил хүүхдүүдийн сайн сайхан байдлыг хангахад бас үүрэг хариуцлага хүлээнэ.
- Монгол улсад хүүхэд хамгааллын чиглэлээр олон хууль үйлчилдэг
- Хүүхэд эрх нь зөрчигдөж байгаа тохиолдолд Хүүхдийн тусламжийн “108” утас руу залгаж мэдэгдэнэ. Сургуульд бол багш, анги удирдсан багш, нийгмийн ажилтнаас тусламж хүснэ. Түүнчлэн өөрийн оршин суугаа сум хорооны хамтарсан багийн ахлагч, цагдаа, нийгмийн ажилтанд хандаж, тусламж аваарай.
- Насанд хүрэгчид, тухайлбал хөрш, багш, эмч, нийгмийн ажилтан нар хүүхдийн эрх нь зөрчигдсөн, хүүхэд эрсдэлтэй нөхцөлд байгаа бол хүүхдийн тусламжийн утас 108-д эсвэл 102-д мэдээлнэ.

Алхам 4. Дүгнэлт – 10 минут

Хичээлийг нэгтгэж, дараах санааг дүгнэлт маягаар дахин тайлбарлаарай:

- Онцгой хэрэгцээ, эмзэг байдлын улмаас эрүүл энх өсөж хөгжихөд хүүхдүүд онцгой халамж, хамгаалал шаарддаг.
- Хүүхдийн эрхийн бүх зарчмууд дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөгдсөн.

- Эдгээр эрхийг хамгаалж, мөрдөх явдлыг хангах зорилгоор НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенц батлагдаж 196 орон нэгдсэн. Монгол улс 1990 онд ХЭК-д нэгдэн орж хүүхдийн эрхийг хангах чиглэлээр үүрэг хүлээсэн.
- Тусламж хэрэгтэй байгаа хүүхдийг үл ойшоож болохгүй. Насанд хүрэгчид хүүхдүүдийг хамгаалах үүрэгтэй.
- Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд мэдээлэх, тусламж хүсэх арга замаа тодорхойлох:
 - ✓ Хүүхдийн тусламжийн “108” утас
 - ✓ Цагдаагийн “102” утас
 - ✓ Ангийн багш
 - ✓ Сургуулийн нийгмийн ажилтан
 - ✓ Дотуур байрны багш
 - ✓ Хүүхдийн эрхийн улсын байцаагч
 - ✓ Сум, хорооны хамтарсан баг (Засаг дарга, цагдаа, өрхийн эмч, нийгмийн ажилтан)
 - ✓ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс
 - ✓ Хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага
 - ✓ Цагдаагийн байгууллага
 - ✓ Аймаг, дүүргийн Өсвөр үеийн клиник

Сэдэв 2.3 Эвлэлдэн нэгдэх миний, бидний эрх



Агуулга

Энэ сэдвээс хамтран ажиллахын ач холбогдлын талаар мэдэж авна. Сургалтад оролцогчид нэг зорилгын төлөө хэрхэн хамтран ажиллах талаар туршлагатай болно.



Үндсэн мэдээлэл

- Хүн бүр эвлэлдэн нэгдэх эрхтэй.
- Багт хамрагдсанаар та илүү хүчтэй болно.
- Гэр бүл, орон нутаг, бүс, үндэсний, олон улсын зэргээр бүх түвшинд ерөнхий зорилгодоо хүрэх хамтын ажиллагаа шаардлагатай байдаг.
- Нэг зорилгод хүрэхийн тулд багийн гишүүдийн ялгаатай байдлыг хүндлэх асуудал ихэд чухал юм. Учир нь хүн нэг бүр өөрийн гэсэн чадвар, чадамжтай байдаг бөгөөд хамтын зорилгод хүрэхэд өөрийн хувь нэмрээ оруулдаг.
- Эвлэлдэн нэгдэх гэдэг нь бүх хүний үндсэн эрхийн нэг юм. Энэ эрх нь:
 - ✓ Тайван замаар хуран цуглах эрх
 - ✓ Хамтран нэгдэх эрх
 - ✓ Хувь хүн аливаа холбоо, байгууллагад нэгдэх эс нэгдэх эрх
 - ✓ Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрхийг агуулдаг.



Дасгалууд

2.4.1 Олуулаа хэлэлцвэл буруугүй – эвлүүлдэг тоглоом

2.4.2 Эвлэлдэн нэгдэцгээе



Холбогдох сэдвүүд

5.2 Багаар ажиллах ур чадвар

11.2 Хөдөлмөрлөх эрх

Дасгал 2.3.1 Олуулаа хэлэлцвэл буруугүй – эвлүүлдэг тоглоом



Зорилго

- Хамтран ажиллахад өөрийн хүч чадлаа дайчлахын ач холбогдлыг ойлгох
- Хамтран ажиллахын давуу талыг мэдрэх



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Ширээгээ тойрч сууна



Ашиглах материал

- Баг бүрт эвлүүлдэг тоглоом (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1 А)
- Ажиглагчийн тэмдэглэл хөтлөх хуудас (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1 Б)



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.3.1 А: Дүрс эвлүүлэх тоглоом

2.3.1 Б: Ажиглагчийн тэмдэглэл хөтлөх хуудас

Нэмэлт мэдээлэл: Эвлэлдэн нэгдэх эрх ба дүрс эвлүүлэх аргачлал



Сургалт зохион байгуулах алхмууд¹⁵

1. Багт хуваарилж тоглоомын дүрмийг танилцуулах – 10 минут
2. Хоорондоо ярихгүйгээр дүрс эвлүүлэх – 10 минут
3. Хэлэлцүүлэг – 30 минут
4. Эвлэлдэн нэгдэх талаар дүгнэж ярилцах – 10 минут

¹⁵ Эх сурвалж: *Health Care Together: Training Exercises for Health Workers in Community Based Programmes* by Mary P. Johnston & Susan B. Rifkin (Macmillan Publishers Ltd.: London, 1987), Exercise: Broken Squares, p. 57-60.

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1 А-д заасны дагуу бүлэг бүрт эвлүүлдэг тоглоом бэлдэнэ

Алхам 1. Багт хуваарилж тоглоомын дүрмийг танилцуулах – 10 минут

Оролцогчдыг 6 хүнтэй багуудад хуваарилна. Баг бүрийн 5 гишүүн суудалдаа сууна. Багийн нэг гишүүн нь ажиглагчаар ажиллана. Ажиглагч өрөөний дундуур алхана.

Баг бүрт тоглоомын дүрмийг танилцуулна:

- Хүн бүрт 3 ширхэг дүрс өгнө.
- Гурван хэсгээр 5 дөрвөлжин дүрс байгуулна.
- Хэн ч ярьж эсвэл дохио өгч болохгүй.
- Оролцогчид бие биедээ дүрс дамжуулж болох ч өөрийн багийн гишүүдээс тусламж хүсэхгүй.

Тоглоомын дүрмийг ойлгосон эсэхийг асуугаарай.

Ажиглагч хийх хүн бүрт тоглогчдын зан үйлийн аль талд анхаарахыг чиглүүлсэн Ажиглагчийн хуудас өгнө (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1.Б). Бичиг үсгийн чадвар багатай ажиглагч байвал зааварчилгааг тайлбарлаж өгч болно. Ажиглагч нь өөрийн багийн гишүүдтэйгээ ажиглалтын хуудсын талаар санал солилцохгүй. Ажиглагч багийн гишүүд дүрсийг хэрхэн эвлүүлж байгааг ажиглаж, зааварчилгааны дагуу тэмдэглэл хөтлөх үүрэгтэй.

Алхам 2. Хоорондоо ярихгүйгээр дүрс эвлүүлэх – 10 минут

Багийн гишүүд хоорондоо ярихгүйгээр 10 минутын хугацаанд 5 дүрс эвлүүлнэ.

Алхам 3. Хэлэлцүүлэг – 30 минут

Ажиглагчдаас багийн ажлын тухай асуугаарай. Дараах асуултыг асууж хэлэлцүүлгээ эхэлнэ:

- Аль нэг баг 5 дүрсийг эвлүүлж чадсан уу?
- Хэн нэг нь дүрэм зөрчсөн үү?
- Дүрэм зөрчсөний дараа өөрийгөө хүчтэй мэт мэдрэв үү? Хэрвээ тийм бол яагаад?
- Багийн гишүүд баг дотроо бүгд ижил байр байдалтай байсан уу? Үгүй бол ямар ялгаа ажиглагдсан бэ? Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн (оход, хөвгүүдийн) зан үйлийн хооронд ялгаа ажиглагдсан уу?
- Энэ нь ажлын үр дүнд сайн эсвэл муу үр дагавартай байсан уу?
- Хоорондоо ярихгүйгээр, хэн нэгнээс тусламж хүсэхгүйгээр дүрсийг эвлүүлэх хэцүү байсан уу?
- Танд хэсгүүдийг хэн өгсөн бэ? Өөрийнхөө дүрсийг хэн нэгэнд яагаад өгсөн бэ?
- Зорилгодоо хүрэхэд заавал зохион байгуулалттай байх хэрэгтэй юу?
- Зохион байгуулалттай байх нь чухал уу үгүй юу? Яагаад?
- Хувийн зохион байгуулалтаа хэрхэн хийхээ та мэддэг үү?
- Та өөрийн туршлагаас жишээ гаргаж чадах уу?
- Ер нь амархан байна уу? Юу нь санаснаар болоогүй вэ? Юу нь зөв гольдролоороо болсон бэ?
- Эвлэлдэн нэгдэх эрхийн тухай та юу мэдэх вэ?

Алхам 4. Эвлэлдэн нэгдэх, зохион байгуулах талаар ярилцах – 10 минут

Эвлэлдэн нэгдэх эрхийн утга санааг тайлбарлаарай. Нэг хүний хүч чадал олон хүний хүчийг гүйцэхгүй бөгөөд хүмүүс нэгдэж, хамтарсны ачаар илүү ихийг бүтээж чадна гэдгийг хэлээрэй. Хүмүүсийн нэг нэгээрээ хүч хүрэхгүй, хүрч чадахгүй зорилгод хүрэхийн тулд хамтын санаачилга, хамтын ажиллагаа зайлшгүй байдаг. Багаараа ажиллахад хамтрах, бүлгийн хэм хэмжээг хүндлэх, өгөх, хуваалцах, дүгнэлт, шийдвэр гаргахад хүлээцтэй байх шаардлага гардаг. Ерөнхийдөө зорилгодоо хүрэхийн тулд ганцаараа байхаас илүү багаар ажиллахад хүчирхэг байдаг тул маш их давуу талтай (Эвлэлдэн нэгдэх эрх, “эвлүүлдэг тоглоом” дасгалыг ажиллуулах талаар нэмэлт мэдээллээс харна уу).



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Ганцаараа байхаас олуулаа байхын давуу талыг тайлбарлаж үзүүлэх. Жишээлбэл: нэг хуруугаараа дуу гаргах, дараа нь 2 хуруугаараа, дараа нь 3, 4 хуруугаараа, дараа нь таван хуруугаа нийлүүлээд алга ташиж үзүүлэх. Ингэж үзүүлсний дараа нэг хүн алга таших, дараа нь 2 хүн нийлээд алга таших, дараа нь 3, 4 хүн гэх мэтээр хүний тоо нэмэгдэх тусам алга ташилтын хэмнэлд анхаарлыг нь хандуулах. Ийнхүү хүн нэмэгдэх тусам гаргах дуу авиа нь илүү чанга хүчтэй болно. Эсвэл нэг эсвэл хоёр мөчир хугалах нь багцалсан 10 мөчир хугалахаас хялбар байдаг.






Даарах ойлголтын хүрээнд бүлгээр ярилцаж дүгнэлт хийнэ:

- Хүн бүр эвлэлдэн нэгдэх эрхтэй.
- Багт хамрагдсанаар та илүү хүчтэй болно.
- Хамтын зорилгодоо хүрэхийн тулд гэр бүл, орон нутаг, бүс, үндэсний, олон улсын зэргээр бүх түвшинд хамтрах шаардлагатай байдаг.
- Нэг зорилгод хүрэхийн тулд багийн гишүүдийн ялгаатай байдлыг хүндэтгэх нь маш чухал. Учир нь хүн нэг бүр өөрийн гэсэн чадвар, чадамжтай байдаг бөгөөд хамтын зорилгодоо хүрэхэд өөрийн хувь нэмрээ оруулдаг. Зарим хүн удирдан зохион байгуулах чадвар сайтай байдаг бол зарим хүн тодорхой салбарын дадал, чадвар, туршлагатай байж, багийн зорилгод хүрэхэд өөрийн хувь нэмрээ оруулж болно.



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1 А: Дүрс эвлүүлэх тоглоом

Зааварчилгаа: Баг бүрт дараах хуудсыг хувилж бэлдэнэ. Таван дүрсийг хэсгүүдээр хайчлаад, хооронд нь сайн холиорой. 5 хэсэг бүхий багцыг нэг уутанд хийнэ. Багийн гишүүн бүрт 3 ширхгийг өгнө (квадрат үүсгэхгүй дүрс байх ёстой).





Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.1 Б: Ажиглагчийн тэмдэглэл хөтлөх хуудас

Зааварчилгаа: Энэ хуудсыг олшруулан хэвлэж ажиглагч бүрт өгнө.

Багийн гишүүн бүрийг ажиглана. Дараах зүйлийг анхаараарай:

- Хэн нь дүрэм зөрчиж байна вэ?
- Дүрмээ хэрхэн яаж зөрчиж байна вэ?
- Хэн нь бусад руу харж, тусламж хүсэж байна вэ?
- Асуудлыг шийдвэрлэх аргыг хэн хамгийн түрүүнд олсон бэ?
- Хэн удирдан чиглүүлж байна вэ?
- Хэн нэг нь үйл явцыг эсэргүүцэж байна уу?

Та дор тэмдэглэл хөтөлж болно:



Нэмэлт мэдээлэл: Эвлэлдэн нэгдэх эрх ба дүрс эвлүүлэх аргачлал

Нийтлэг сонирхлыг илэрхийлсэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор баг бүрдүүлэх, зохион байгуулах, хамтрах, тайван хуран цуглах эрх нь хүний эрхүүдийн нэг юм. Зохион байгуулах ур чадвар нь жирийн иргэд засгийн газарт, удирдлагын түвшний хүмүүст нөлөөлөхөд туслах чухал хэрэгсэл болдог. Учир нь жирийн нэг иргэний хүч чадал, 5, 10, 20, 50 эсвэл 100 жирийн иргэний хүч чадлыг гүйцэхгүй. Ажлын байранд ч гэсэн зохион байгуулах чадвар маш чухал юм. Тухайлбал, ажлын байрны аюулгүй байдлыг хангах, цалин хөлс, ажлын цагийн хуваарилалт, шударга ёс гэх мэт асуудлууд гарах үед ажилтнууд хамтраад ажил олгогчдод нөлөөлөх боломжтой. Эвлэлдэн нэгдэх эрх нь олон улсад болон орон нутгийн хуулиар хамгаалагдсан байдаг. Энэ эрх аль ч асуудлыг зохицуулахад чухал. Олон нийтийн жагсаал цуглаан нь энэ эрхээ эдэлж байгаагийн нэг хэлбэр юм.

Олон улсын болон бүсийн гэрээ хэлэлцээр, хөдөлмөрийн олон улсын стандартууд эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөөтэй холбоотой эрхүүдийг хамгаалдаг. Үүнд:

- Тайван хуран цуглах эрх
- Эвлэлдэн нэгдэх эрх
- Ямар нэг холбоонд элсэх эс элсэх эрх
- Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх

Дүрс эвлүүлэх аргачлалын тухайд

Баг бүрдүүлж, тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хамтран ажиллах нь тийм ч амар зүйл биш. Амар биш болохыг “Дүрс эвлүүлэх” дасгал харуулсан. 5 дөрвөлжин дүрс эвлүүлэх даалгавар ихэд хялбар мэт. Гэвч оролцогчид хамгийн сүүлд 3 эсвэл 4 квадрат байгуулж, хоорондоо тохирохгүй хэсгүүдтэй үлдсэн. Нэг квадрат эвлүүлэх хувь хүний хүсэл нь бүх таван квадратыг эвлүүлэх багийн зорилгын хувьд хоёрдогч ач холбогдолтой болохыг оролцогчид ойлгоно. Хувь хүний амжилт нь багийн амжилттай тэнцэх нь ховор бөгөөд багийн амжилтад хүрэхэд саад тотгор ч болж болно. Нэг хүний сайн шийдэл нь бүхэл багийн сайн шийдэлд саад болж болно.

Тоглоомын дүрмэнд баг бүр өөрийн дүрмийг тогтоож болно. Хэлэлцүүлгийн үеэр дараах хувилбарууд гарч ирнэ:

Тохиолдол: Нэг оролцогч бүх хэсгүүдийг хамтрагчдаа өгөх.

Дүгнэлт: Хэн нэг нь хариуцлага хүлээхээс татгалзаж, өөр нэгэнд тохоход багийн ажиллагаа хүндрэлтэй болно.

Тохиолдол: Багийн гишүүн квадратаа эвлүүлж дууссаны дараа сэтгэл хангалуун байж, бусад оролцогчдыг үл ойшооно.

Дүгнэлт: Багийн нэг оролцогч өөрийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байж, бусад оролцогчдын ажилд санаа тавихгүй бол багийн ажил амжилтгүй болно.

Тохиолдол: Тохирох хэсэг нь нөгөө оролцогчид байж, түүнийгээ өгөхийг хүсэхгүй байгаад багийн нэг гишүүн бухимдана.

Дүгнэлт: Багийн гишүүн бусад гишүүдийнхээ хэрэгцээг ойлгож мэдрэхгүй байснаас багийн ажил амжилтгүй болно.

Тохиолдол: Багийн гишүүн хэрэгтэй дүрсийг нөгөө гишүүнээс авахдаа маш их баяртай байна.

- Дүгнэлт: Бусдын хэрэгцээг ойлгодог гишүүний ачаар багийн ажил сайжирлаа.
- Тохиолдол: Нэг оролцогч нөгөө гишүүндээ туслах зорилгоор түүнтэй харилцаж (үгээр эсвэл дохиогоор) дүрэм зөрчсөн.
- Дүгнэлт: Багийн ажилд гишүүд хоорондоо харилцах хэрэгтэй.

Дасгал 2.3.2 Эвлэлдэн нэгдэцгээе



Зорилго

- Хамтын ажиллагаанд хувь хүний хүчин чармайлтын чухлыг ойлгох
- Зорилгодоо хамтдаа хүрэх



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

60 минут



Суудал зохион байгуулалт

Чөлөөтэй явах том зай гаргах



Ашиглах материал

- Эрдэнэсийн хайрцаг, хайрцаг эсвэл самбарын цаасан дээр хайрцаг зурж болно.
- Хүний хөлийн мөрийн зургийг олшруулах (Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.2 А), 2 хүний дунд нэгийг өгнө (нэг оролцогч баруун, нөгөө нь зүүн хөлийн мөрийн зураг авна)



Сургалтын хэрэглэгдэхүүн

2.3.2 А: Хөлийн мөрийн зураг



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Хөлийн мөрийн зураг ашиглаж тоглож эхлэх – 5 минут
2. Нэг хөлийн мөрөөр эрдэнэсийн хайрцагт хүрэх оролдлого хийх- 10 минут
3. Жижиг багаар дахин оролдлого хийх – 10 минут
4. Эрдэнэсийн хайрцагт хүрэхийн тулд зохион байгуулалт хийх – 10 минут
5. Хэлэлцүүлэг – 20 минут
6. Дүгнэлт – 5 минут

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.2 А-г олшруулна эсвэл А4 хэмжээтэй цаасан дээр хөлийн мөр зурж, оролцогч бүрт өгөхөөр бэлдэнэ. Эрдэнэсийн хайрцгаа өрөөний нэг буланд тавиарай. Эрдэнэсийн хайрцгаас 6 алхам зайтай өрөөний нөгөө буланд шугам татна. Шугамын ард бүх оролцогч зогсохоор зайтай байна.

Алхам 1. Хөлийн мөрийн зургаа ашиглаж тоглож эхлэх – 5 минут

Оролцогч бүрт хөлийн мөрийн зураг өгнө. Эгнээний ард бүх оролцогчдыг зогсохыг хүснэ. Тоглоомын зорилго нь хөлөө газар хүргэхгүйгээр эрдэнэсийн хайрцагт хүрэхэд оршино. Хөлөө газар хүргэх зөвшөөрөгдсөн газар нь зөвхөн шугамын ард. Эрдэнэсийн хайрцагт хүрэх шугамын урдуур оролцогчид зөвхөн хөлийн мөрийн зураг дээр хөлөө тавьж явна. Оролцогч бүрийг нэг хөлийн мөрийн зурагтайгаар эрдэнэсийн хайрцагт хүрэхийг санал болгоорой. Энэ нь боломжтой юу? (Үгүй)

Алхам 2. Нэг хөлийн мөрөөр эрдэнэсийн хайрцагт хүрэх оролдлого хийх – 10 минут

Эрдэнэсийн хайрцагт хүрэхийн тулд тэдэнд юу хэрэгтэй вэ гэж оролцогчдоос асууна. Хөлийн мөрийн дахиад хэд хэдэн зураг хэрэгтэй байна гэвэл өөр зураг байхгүй гэж хариулна. Баг байгуулъя гэсэн санал гаргавал хос хосоороо болохыг зөвшөөрнө. Оролцогчид баг байгуулах санал гаргахгүй бол тэднийг хос хосоороо болохыг санал болгоно. Оролцогчдыг эрдэнэсийн хайрцагт хүрэх оролдлого дахин хийхийг санал болгоно. Гэхдээ хоёр оролцогч хоёулаа хайрцагт хүрэх ёстой гэдгийг сануулаарай. Энэ нь боломжтой юу? Үгүй.

Алхам 3. Жижиг багаар дахин оролдлого хийх – 10 минут

Эрдэнэсийн хайрцагт хүрэхийн тулд тэдэнд юу хэрэгтэй болохыг оролцогчдоос дахиад асууна. Гурван хүнтэй баг бүрдүүлж эрдэнэсийн хайрцагт хүрэх оролдлого дахин хийнэ. Энэ нь бас л боломжгүй зүйл юм.

Алхам 4. Эрдэнэсийн хайрцагт хүрэхийн тулд зохион байгуулалт хийх – 10 минут

Оролцогчдыг өөрсдийнхөө хүсэж байгаагаар зохион байгуулалт хийхийг санал болгоно. Ихэвчлэн оролцогчдын нас болон тооноос хамаарч 6-8 хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулна. Багийн гишүүн бүр хөлийн мөрөөр дамжин эрдэнэсийн хайрцагт хүрнэ.

Алхам 5. Хэлэлцүүлэг – 20 минут

Бүх оролцогч эрдэнэсийн хайрцагт хүрсний дараа тэднийг суудалдаа суухыг урина. Дараах асуултын дагуу үйл ажиллагаагаа хэлэлцэнэ:

- Асуудлын шийдлийг олоход хэцүү байсан уу?
- Цөөн хүнтэй багийн хувьд ямар гол бэрхшээл үүссэн бэ?
- Хэн шийдэл олсон бэ? Нэг хүн үү эсвэл олон хүн үү?
- Нэгээс дээш шийдэл байсан уу?
- Удирдан зохион байгуулах хүн хэрэгтэй байсан уу?
- Бусад гишүүдийн тусламж дэмжлэг хэрэгтэй байсан уу?

- Та юу сурсан бэ?
- Ажлын байран дээр болон өөрийн орон нутагт багаар ажиллахын давуу талыг нотлох жишээ хэлнэ үү?
- Та ажлын байрандаа болон амьдарч байгаа газартаа ямар нэг баг, бүлэгт харьяалагддаг уу? Тийм/Үгүй бол яагаад?

Алхам 6. Дүгнэлт – 5 минут

Зорилгодоо хүрэхийн тулд баг болон хамтарч ажиллах нь үр дүнтэй байдаг гэсэн дүгнэлт хийнэ. Зохион байгуулалт нь илүү хүч чадал, давуу тал өгөх болно. Бүх хүнд дараах эрх байдгийг онцлон хэлээрэй. Үүнд:

- Тайван хуран цуглах эрх
- Эвлэлдэн нэгдэх эрх
- Ямар нэг холбоонд элсэх эс элсэх эрх
- Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх



Сургалтын хэрэглэгдэхүүн 2.3.2 А: Хөлийн мөрийн зураг

Зааварчилгаа: Энэ хуудсыг хоёр оролцогчид нэг хувь оногдохоор хувилаарай. Түүнээс гадна А4 хэмжээтэй цаас эсвэл самбарын цаасан дээр хөлийн мөрийн зураг зурж хайчлаад оролцогч бүрт нэг хөлийн мөрийн зураг өгнө.



УНШИХ МАТЕРИАЛ

Carl, Greg & Chaiphech, Nonthathorn, *Friends Tell Friends on the Street*, Thai Red Cross Aids Research Centre: Bangkok, 2000.

Fountain, Susan, *It's Only Right! A Practical Guide to Learn More about the Convention on the Rights of the Child*, UNICEF: New York, 1993.

Haspels, Nelien & Suriyasarn, Busakorn, *Promotion of Gender Equality in Action against Child Labour and Trafficking: A Practical Guide for Organizations (GECL-Guide)*, ILO: Bangkok, 2003.

ILO, *Child Labour – An Information Kit for Teachers, Educators and Their Organizations*, IPEC: Geneva, 1998.

ILO, *Supporting Children's Rights through Education, Arts and the Media (SCREAM) – Stop Child Labour Education Pack*, IPEC: Geneva, 2002.

Johnston M.P. & Rifkin, S.B., *Health Care Together: Training Exercises for Health Workers in Community Based Programmes*, London, 1987.

Northern Ireland Human Rights Commission (NIHRC), *Inspiring Practice: Resources, Tools and Activities for Human Rights Education* by Northern Ireland Human Rights Commission (2008), http://www.nihrc.org/uploads/publications/Inspiring_Practices.pdf.

Pretty, Jules N., Guijt, Irene, Scoones, Ian & Thompson, John, *A Trainer's Guide for Participatory Learning and Action*, IIED Participatory Methodology Series: London, 1995.

Save the Children, *Child Rights Situation in Mongolia 2018*.

Terhorst, Rosalinda, Haspels, Nelien, Gender and Development for Cambodia (GAD/C) & Expansion of Employment Opportunities for Women (EEOW), *Women Workers' Rights and Gender Equality: Easy Steps for Workers in Cambodia (WWRGE Manual – Cambodia)*, ILO: Bangkok, 2004.

Centre for Civic Education, Teachers Resources, URL: <http://www.civiced.org>

Human Rights Education Associates, Electronic Resource Centre for Human Rights Education, URL: <http://www.hrea.org>

Human Rights Resource Center, University of Minnesota, Human Rights Here and Now, URL: <http://hrlibrary.umn.edu/edumat/hreduseries/hereandnow/Part-3/Activity1.htm>

International Programme on the Elimination of Child Labour (IPEC), URL: <http://www.ilo.org/ipec/lang--en/index.htm>

Mongolian law information: <https://www.legalinfo.mn/law>

UNICEF, Resource Guide for Students and Teachers,

URL: <https://www.unicef.org/siteguide/resources.html>land

URL: <https://www.unicef.org/magic/>

Амьдрах ухааны сургалт

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо

Модуль 2. Бидний эрх

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат”-ны хүрээнд гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ilo.org/mongolia хаягаар авах боломжтой.